



СУВИЛГААНЫ ТҮҮХ ХӨТЛӨХ ЖУРАМ

Хувилбарын дугаар: 02

Хүчин төгөлдөр болсон огноо: 2023-07-05

Баримт бичгийн дугаар:

Баримт бичгийг хариуцах нэгж			
Баримт бичгийн нууцлалын зэрэглэл:	Дотоод	Баримт бичгийн түвшин	2
		Албан тушаал	Гарын үсэг
Боловсруулсан:	Б.Сувд-Эрдэнэ	Сувилахуйн гардан үйлдлийн арга зүйч	
Санал өгч хянасан:	Д.Болормаа	Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал	
Хянаж батласан:	Г.Дашжанцан	БОЭТөвийн захирал	

Баримт бичгийн өөрчлөлтийн бүртгэл

Хувилбарын дугаар	Хүчин төгөлдөр болсон огноо	Өөрчлөлтийг батласан албан тушаалтан	Өөрчлөлтийн утга (баримт бичигт ямар өөрчлөлт орсонг товч тайлбарлана)
1	2018		Баримт бичгийн анхны хувилбар
2	2023		Тодотгол хийв
3			

АГУУЛГА:

ЗОРИЛГО.....	4
ХАМРАХ ХҮРЭЭ.....	4
НЭР ТОМЬЁО, ТОВЧИЛСОН ҮГ, ИШ ТАТСАН БАРИМТ БИЧГҮҮД.....	4
БОЭТӨВИЙН СУВИЛГААНЫ ТҮҮХ БОЛОН БУСАД МАЯГТ ЗААВАР	6
СУВИЛГААНЫ ТҮҮХ БОЛОН МАЯГТЫГ ХӨТЛӨХ ЗӨВЛӨМЖ	9
СУВИЛГААНЫ ТҮҮХ БОЛОН МАЯГТУУД	11
ЖИШИГ СУВИЛГААНЫ ТҮҮХ	21
ХОРИГЛОХ ЗҮЙЛ	56
ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭ.....	56

НЭГ. ЗОРИЛГО:

Энэхүү журмын зорилго нь Бүсийн Оношилгоо эмчилгээний төвийн /цаашид БОЭТ-ийн гэх/ “Сувилгааны түүх ” хөтлөх үндсэн зорилго нь Сувилагч эмчлүүлэгчийн биеийн байдалд тогтмол үнэлгээ, дүгнэлт өгч авах арга хэмжээг төрөлжсөн сувилахуйд үндэслэн төлөвлөн хэрэгжүүлэх, мэргэжлийн үйл ажиллагаа явуулсан тухайг баримтжуулах, эмчлүүлэгчид үзүүлэх тусламж үйлчилгээний чанарыг сайжруулахад оршино.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ:

БОЭТ-ийн сувилагч, эх баригч мөрдөнө.

ГУРАВ. НЭР ТОМЪЁО, ТОВЧИЛСОН ҮГ, ИШ ТАТСАН БАРИМТ БИЧГҮҮД

Нэр томъёо

СМ- Сувилгааны маягт

СТ- Сувилгааны түүх

САЗ-Сувилахуйн арга зүйч

БОЭТ-Бүсийн оношилгоо эмчилгээний төв

Иш татсан баримт бичиг

- Эрүүл мэндийн сайдын 2019 оны 611 дугаар тушаал,
- Сувилгааны түүх хөтлөх явцад Сувилгааны асуудал буюу оношийг олон улсын “NANDA” байгууллагаас баталж гаргасан 50 оношийн дагуу бичих боловч өөрийн байгууллагын онцлогт тохируулан гаргасан оношийг хэрэглэж болно.
- Эрүүл мэндийн сайдын 2015 оны 497 дугаар тушаал
- 2012 оны Эх нярайн тусламж үйлчилгээний хяналтын хуудас 256- р тушаал
- Нярайн эрт үеийн тусламж үйлчилгээ 2018 оны А/545-р тушаал
- Сэтгэцийн тасагт Эрүүл мэндийн сайдын 180 дугаар

ДӨРӨВ. Процессийн үүрэг хариуцлага / RACI матриц /

№	ПРОЦЕСС	СУВИЛАГЧ	СУВИЛАХУЙН АРГА ЗҮЙЧ	ТАСГИЙН ЭРХЛЭГЧ	СУВИЛАХУЙН АЛБА	ЭТҮЧАБА	ЭХ БАРИГЧ	АХЛАХ ЭХ БАРИГЧ	ЭЭДЭ
1	Үйлчлүүлэгчийг сувилгааны үнэлгээний хуудсаар үнэлэх	RA	AC	CI	CI				
2	Сувилгааны онош тавих	RA	AC	CI	CI				
3	Сувилгааны төлөвлөгөө боловсруулах	RA	AC	CI	CI				

4	Сувилгааны хэрэгжүүлэлт бичих	RA	AC	CI	CI				
5	Сувилгааны дүгнэлт бичих	RA	AC	CI	CI				
6	Үйлчлүүлэгчийн давтан үнэлгээг хийх	C	RAC	CI	CI				
7	Сувилгааны маягт хөтлөлт	RA	RAC	CI	CI	I			
8	Эрчимт эмчилгээний хуудас хөтлөлт	RA	RAC	CI	CI				
9	Эх барихын хяналтын хуудас бичилт			CI	CI	I	RA	RAC	I
8	Сувилгааны түүх, маягт бичилтэнд хяналт тавих		RA	RA	CI	I			I
9	Сувилгааны маягт хөтлөлт	RA	RAC	CI	CI		RA	RAC	
10	Өдөр тутмын үнэлгээ дүгнэлт өгөх	C	RA	RA	RA	RA			
11	Сургалт арга зүйгээр хангах		RAC	RA C	RAC	I			I

/ R- гүйцэтгэх, A-хариуцах, C-хамтран ажиллах, I -мэдээлэлтэй байх

ТАВ . БОЭТӨВИЙН СУВИЛГААНЫ ТҮҮХ БОЛОН БУСАД МАЯГТУУДЫГ ХӨТЛӨХ ЗААВАР

5.1 /СТ-02 хавсралт – 2 / Эмчлүүлэгчийн амин үзүүлэлтийн хуудас/,

СМ-1 хавсралт – 11 / Сувилагч эмчлүүлэгчийн биеийн байдлыг үнэлэх хуудас/, СМ-2 хавсралт – 12 / Сувилгааны тэмдэглэл/, СМ-3 хавсралт -13 /Өвдөлт хянах хуудас/, СМ-4 Хавсралт -14/ Шингэний баланс хянах хуудас/,СТ -02 хавсралт -4/ Эрчимт эмчилгээний хуудас/

5.2 Сувилгааны түүх нь сувилахуйн мэргэжлийн тусламж үйлчилгээг үзүүлсэн тухайг баримтжуулан, хуулийн өмнө нотолгоо болох үүднээс өвчний түүхийн хамт хадгалагдана.

5.3 СТ -01 хавсралт -1 /эмчлүүлэгчийн эмийн хуудсыг / сувилах эрх бүхий сувилагч, хэвтэн эмчлүүлэх тасаг болон өдрийн эмчилгээний буй хүүхэд болон насан хүрэгчид хөтөлнө.

5.4 /СТ-02 хавсралт – 2 /эмчлүүлэгчийн амин үзүүлэлтийн хуудсыг/ эрх бүхий сувилагч, эх баригч, бага эмч хэвтэн эмчлүүлж байгаа хүүхэд болон насан хүрэгчидэд хөтөлнө

5.5 СМ-1 хавсралт – 11/ Сувилагч эмчлүүлэгчийн биеийн байдлыг үнэлэх хуудас/ , /СМ-2 хавсралт – 12 Сувилгааны тэмдэглэл / хуудсыг Халдварт, Сүрьеэ, Мэдрэл, Мэс засал, Гэмтлийн тасаг, Дотор-Арьсны клиник, Чих Хамар,Хоолой Эрүү Нүүр Нүдний Мэс заслын тасаг, Уламжлалтын тасаг, Наркологи, Хөнгөвчлөх, Эмэгтэйчүүдийн тасагт хэвтэн байгаа эмчлүүлэгчдийн биеийн байдал ДУНД тохиолдолд СМ-1 хавсралт – 11 / Сувилагч эмчлүүлэгчийн биеийн байдлыг үнэлэх хуудас/, СМ-2

хавсралт – 12 / Сувилгааны тэмдэглэлийн хуудсыг/ хэвтэн эмчлүүлж хугацаанд 3 удаа үнэлж төлөвлөгөөг боловсруулах, хэвтэн эмчлүүлэгч ХҮНДЭВТЭР тохиолдолд СМ-1 хавсралт – 11, СМ-2 хавсралт – 12 хуудсыг өдөр бүр үнэлж, сувилах төлөвлөгөөг боловсруулах, хэвтэн эмчлүүлэгч ХҮНД тохиолдолд СМ-1 хавсралт – 11, СМ-2 хавсралт – 12 хуудсыг жижүүр хүлээлцэх бүрт үнэлж, сувилах төлөвлөгөөг боловсруулах, Шаардлагатай тохиолдолд Биеийн байдал ХҮНД, МАШ ХҮНД үйлчлүүлэгчид Эмчлэгч эмчийн бичсэн СТ -01,02 хавсралт -4 хуудсыг эмчлэгч эмч нээж сувилагч хөтлөнө.

5.6 СМ-3 хавсралт -13 / Өвдөлт хянах хуудсыг / хэвтэн эмчлүүлж байгаа эмчлүүлэгч бүрд өвдөлтийг үнэлэх багасгах зорилгоор авч хэрэгжүүлнэ.

5.7 СМ-3 хавсралт -13 / Өвдөлт хянах хуудсыг / авсан тохиолдол бүрт өвдөлт хянах хуудсыг хаана. / өвдөлт намдсан, өвдөлтгүй болсон тул өвдөлт хянах хуудсыг хаав/

5.8 СМ-4 Хавсралт -14 Шингэний баланс хянах хуудсыг бөөлжилттэй, суулгалттай, хавагнасан, амьсгаадалттай, түлэгдэлттэй, хөлдөлттэй, хордлоготой, олон эрхтний дутмагшилтай үйлчлүүлэгчид эмчлэгч эмчтэй хамтран хөтөлж хэрэгжүүлнэ.

5.9 Эх барих эмэгтэйчүүд, Жирэмсний эмгэг тасагт төрөх эхийн хяналтын хуудас, төрсний дараах эхийг хянах хяналтын хуудсыг хөтөлнө.

5.10 Яаралтай тусламжийн тасагт эрэмбэлэн ангилалтын хуудас, алс болон төвийн дуудлагын хуудас, Гемодиализ эмчилгээний хуудас, гемодиализийн үеийн амин үзүүлэлт хяналтын хуудсыг хөтөлнө.

5.11 Сэтгэцийн тасагт Эрүүл мэндийн сайдын 180 дугаар тушаалаар сувилгааны түүхийг хөтөлнө.

5.12 Эрчимт эмчилгээний тасагт хэвтэн эмчлүүлж байгаа үйлчлүүлэгчид, бусад тасагт хэвтэн эмчлүүлж байгаа МАШ ХҮНД болон ХҮНД 0-16 насны хүүхдүүд, эмчилгээтэй нярайд тус тус эмчийн бичсэн эрчимт эмчилгээний хуудсыг хөтөлнө.

5.13 Эрчимт эмчилгээний хуудасны асаргаа сувилгааны хэсэгт өдөр тутамд хийдэг асаргааг бичиж тэмдэглэнэ.

5.14 Эрчимт эмчилгээний хуудасны асаргаа сувилгаанд гарсан өөрчлөлт хэсэгт тухайн үйлчлүүлэгчийн оношийн дагуу төрөлжсөн сувилахуйн тусламж үйлчилгээг үзүүлсэн тухай бичнэ.

5.15 Сувилгааны түүхийг эмчлүүлэгч эмнэлэгт хэвтснээс хойш 24 цагт багтаан хөтөлнө. 24 цаг дотор аль ээлжийн сувилагч эхний үнэлгээг өгөх асуудлыг сувилагчдын ажлын ачааллыг тэнцүүлэх, дотоод зохицуулалтын зарчмаар тасгийн ахлах сувилагч зохицуулна.

5.16 Эмчлүүлэгийн биеийн байдлыг үнэлж тухайн эмчлүүлэгч эмгэг өөрчлөлттэй эсэхийг сувилгааны асуудлын тусгай тэмдэглэл хэсэгт бичиж тэмдэглэнэ. / Хугаралтай, шархтай, хатгагдсан, гуурстай, гэх мэт /.

5.17 Ахлах сувилагч нь Давтан үнэлгээний тусгай тэмдэглэл хэсэгт үнэлгээ өгсөн сувилагчийн тусгай тэмдэглэлд үндэслэн анхаарах шаардлагатай асуудлыг бичиж тэмдэглэнэ.

5.18 Эмчлүүлэгчийн биеийн байдлыг жижүүрийн сувилагч анх үнэлснийг тасгийн ахлах сувилагч шалган баталгаажуулж, давтан үнэлгээг хэдий хугацаанд хийх шаардалагтайг СМ-1 хавсралт – 11 Сувилагч эмчлүүлэгчийн биеийн байдлыг үнэлэх хуудас, СМ-2 хавсралт – 12 хуудасны давтан үнэлгээний хэсэгт бичнэ.

5.19 Үйлчлүүлэгч зовиурласан, анхаарал татсан тохиолдолд ахлах сувилагчийн үнэлэх хугацааг харгалзахгүйгээр СМ-1 хавсралт – 11 Сувилагч эмчлүүлэгчийн биеийн байдлыг үнэлэх хуудас, СМ-2 хавсралт – 12 Сувилгааны тэмдэглэл, СМ-3 хуудсыг бичиж дараагийн ээлжийн сувилагчид хүлээлгэн өгнө.

ЗУРГАА. СУВИЛГААНЫ ТҮҮХ БОЛОН МАЯГТЫГ ХӨТЛӨХ ЗӨВЛӨМЖ

6.1 Амин үзүүлэлт хянах хуудас

6.1.1 СТ-02 хавсралт – 2Эмчлүүлэгчийн амин үзүүлэлтийн хуудсыг Сувилагч эмчлүүлэгчийн овог, нэр, өвчний түүхийн дугаар, нас, хүйс, тасгийн нэр, палатны дугаар, он, сар, өдөр, хэвтсэн хоног, мэс засал хийлгэсэн хоног, үзсэн цаг минутыг бүрэн бичиж тэмдэглэнэ. Сувилагч эмчлүүлэгчийн биеийн халуун, цусны даралт, судасны лугшилт, амьсгалын хэвийн хэмжээндээ байгаа эсэхийг үзэж Амьсгал-Хөх, Биеийн халуун- Хар, Судасны цохилтыг-Улаан өнгийн балаар зохих хүснэгтэд бөглөнө. Мөн цусны даралт, биеийн жин, эмчилгээний хоолны дугаарыг бичиж, өтгөн, шингэний давтамжийг асууж тэмдэглэнэ. сувилагч бүтэн нэрээ бичиж баталгаажуулна. Амин үзүүлэлт өөрчлөлт өгсөн үед цагийг тавина. Захын судасны хүчилтөрөгчийн хангамжийг шаардлагатай үйлчлүүлэгчид бичиж тэмдэглэнэ.

6.2 Сувилагч эмчлүүлэгчийн биеийн байдлыг үнэлэх хуудас

6.2.1 **СМ-1 хавсралт – 11** хөтлөхдөө аль болох үйлчлүүлэгчийн тухтай байрлалд байлган асуух, ярилцах биеийн байдлыг амьсгал зүрх судасны хэсгээс эхлэн үнэлэх, бодит үзлэг хийх хэлбэрээр хөтлөх ба үйлчлүүлэгчийн нэмэлтээр хэлсэн өгүүлэмжийг бичиж тэмдэглэх маягаар хөтөлнө.

6.3 **СМ-1 хавсралт – 11** Сувилагч эмчлүүлэгчийн биеийн байдлыг үнэлэх хуудсыг бичихдээ хаягжилтийн хэсгийг бүрэн бөглөсөн байх, үнэлгээ эхэлсэн он, сар, өдөр, цаг, минут, үйлчлүүлэгчийн биеийн байдлыг бичих, Үнэлгээний асуулт бүрт тохирох хариултыг тус хуудасны ард буй зааврын дагуу тийм, үгүй, хамаарахгүй гэсэн тэмдэглэгээний аль нэгээс сонгон тэмдэглэнэ. Эдгээр тэмдэглэгээний аль нэгийг хоосон нүд үлдээж болохгүй.

6.3.1 Сувилагч тухайн бүлэг асуудлыг үнэлж дуусаад, түүний ард сувилгааны асуудлаас тохирох нэг асуудлыг сонгон түүний дугаарыг дугуйлан, үнэлгээний асуудал төгсгөлд байх сувилгааны асуудал хэсэгт тэмдэглэнэ. Үнэлгээ хийсэн сувилагч бүтэн нэр, үнэлгээ хийгдэж дууссан он, сар, өдөр, цаг минутыг тавих, Ахлах сувилагч үнэлгээг давтан хийх өдрийг бичихдээ он, сар, өдөр, цаг минутыг тавих

6.3.2 Үнэлгээний хэсгийн бүх үзүүлэлт хэвийн гэж үнэлсэн бол эрүүл мэндийн боловсрол олгох төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллана. Дараагийн ээлжийн сувилагч анхаарах асуудлыг бичиж тэмдэглэнэ.

6.4 Сувилгааны үнэлгээг үйлчлүүлэгчээс авсан асуумж болон бодит үзлэгийг үндэслэн сувилгааны оношийг тавина.

6.4.1 сувилгааны ононшийг Олон Улсын NANDA-аас баталсан онош болон БОЭТөвийн жишиг түүхээс оношийг сонгон хэрэглэнэ.

6.5 Сувилгааны тэмдэглэл хуудсанд үйлчлүүлэгчид хийгдсэн асаргаа сувилгаа болон төрөлжсөн сувилахуйн тусламж үйлчилгээг тухай бүрт нь бичиж тэмдэглэх зорилготой.

6.5.1 CM-2 хавсралт – 12 Сувилгааны тэмдэглэлийг бичихдээ хаягжуулалтын хэсгийг бүрэн бичсэн байх, сувилгааны тэмдэглэл эхэлсэн он, сар, өдөр, минутыг бичнэ

6.5.2 Сувилахуйн төлөвлөгөө нь оношийн дагуу асуудлыг шийдвэрлэхийн тулд үзүүлэх асаргаа, сувилгааг хэрхэн, ямар хугацаанд, ямар давтамжтайгаар хийж хэрэгжүүлэх, шийдвэрлэх арга зам, гарцыг үйлчлүүлэгчтэй зөвшилцсөний үндсэн дээр үнэн бодитой бичсэн сувилгааны тэмдэглэл болно.

6.5.3 Сувилахуйн төлөвлөгөөг үйлчлүүлэгчийн эрүүл мэндэд тулгарсан асуудал, зовиур шаналгааг хамтран шийдвэрлэх гол зарчмыг баримтлан, нэн яаралтай, чухлаас нь эхлэн дугаарлан төлөвлөнө.

6.5.4 Сувилахуйн хэрэгжүүлэх үе шат нь төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр сувилагчийн гүйцэтгэсэн ажлыг хэлнэ.

6.5.5 Хэрэгжүүлэлтийн хэсэгт асаргаа сувилгааг хэрхэн, яаж, ямар давтамжтай хийснийг дэлгэрэнгүй бичиж тэмдэглэнэ.

6.5.6 Дүгнэлт хэсэгт асаргаа сувилгааг хийснээр үйлчлүүлэгчийн биеийн байдалд гарсан гол үр дүнг бичиж бүтэн нэрээ бичиж баталгаажуулна.

6.5.7 Эмчлүүлэгчийн биеийн байдлаас шалтгаалан сувилгааны үнэлгээгээр илрүүлсэн асуудлыг бүрэн арилтал авсан арга хэмжээ, үзүүлсэн асаргаа сувилгааг цаг алдалгүй бичиж тэмдэглэнэ.

6.6 Өвдөлт хянах хуудсыг өвдөлтийг үнэлэх, өвдөлтийг багасгах сувилгааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх зорилгоор хэвтэн эмчлүүлэгчид хэрэглэнэ.

6.7 Шингэний баланс хянах хуудас биед орсон болон гарсан шингэний тэнцвэрт байдлыг хянах зорилгоор шингэний балансын хуудсыг хөтөлж гарын үсгээр баталгаажуулна. Шингэний балансын хуудас хөтөлж байгаа үед биеийн жинг өдөр бүр тогтмол үзэж бүтэн нэрээ бичиж баталгаажуулна.

6.8 Эрчимт эмчилгээний хуудсыг хүнд болон Маш хүнд эмчлүүлэгчийн эмчилгээг эмчийн бичсэн заалтаар гардан гүйцэтгэж, амин үзүүлэлтүүдийг цаг тутамд хянаж тэмдэглэн биеийн байдлыг үнэлэхэд оршино.

6.8.1 Эмчлүүлэгчийн эмчилгээний хуудастай танилцахдаа дараах тэмдэг тэмдэглээг баримтлана.

6.8.2 Шахуургаар хийх шингэнийг эмчийн заасны дагуу мл/цагаар тэмдэглэнэ.

6.8.3 Дуслын шингэнийг эмчийн заасны дагуу дөрвөлжин тэмдэглэгээнд дотор Х буюу чагт тэмдэглэгээ хийнэ. Гэхдээ дусал залгаад эхлэхэд эхний зураас, дуусахад бүрэн чагтална.

6.8.4 Судас, булчин тарилга хийхдээ эмчийн заасны дагуу /+/ тэмдэглээг дугуйлна. Эмчлүүлэгчийн амин үзүүлэлтүүдийг хянаж тэмдэглэх

6.8.5 Глазго үнэлгээг хийх ухаан санааг үнэлэх

6.8.6 Өвдөлтийг өвдөлтийн шугамын дагуу үнэлэх / тоогоор /

6.8.7 Биеийн халуун, Артерийн даралт, дундаж даралт, судасны лугшилт, амьсгалын тоо, захын судасны хүчилтөрөгчийн хангамжийг цаг тутамд хянаж бичнэ.

6.8.8 Зохиомол амьсгалын аппаратны хэлбэр, эзлэхүүн, даралт, шахалт, хүчилтөрөгч өгөлтийг эмчийн заалтын дагуу бичиж тэмдэглэнэ

6.9 Шингэний баланс тооцолт

Эмчлүүлэгчийн биеэс гадагшлах биологийн шингэний хэмжээг гарсан тохиолдол бүрт тэмдэглэх /ходоодны агууламж, гуурсаар гадагшлах шингэн, шээс, өтгөн г.м/

6.9.1 Эмчлүүлэгчийн биед орох шингэнийг нарийн хэмжиж тэмдэглэх / зондоор хооллох, амаар уусан/

6.9.2 Орсон зүйлийг нэг бүрчлэн тооцох / амаар, судсаар, булчин тарилга, шахуургаар хийсэн шингэн, арьсан дор тарилга, эм даруулсан ус гэх мэт /

6.9.3 Эмчлүүлэгчид хийгдсэн төрөлжсөн сувилахуй болон асаргааг бичиж тэмдэглэнэ.

6.9.4 Асаргаа сувилгааны тэмлэглэх хэсэгт өдөр тутамд хийгдэх асаргаа сувилгааг + тэмдэгээр төлөвлөж, хийсэн цаг бүрт нь дугуйлж баталгаажуулна. / цээж өндөрлөх, цэр салст соруулах, байрлал сэлгэх, угаалга хийх гэх мэт/

6.9.5 Нэмэлт тэмдэглэгээ оруулах бол цаг минут сери дугаарыг бичих / Интубаци, экстубаци тавьсан хийсэн цаг, хортын болон мансууруулах сэтгэцэд нөлөөт эмийн серий дугаарыг бичих гэх мэт /

6.9.6 Туслах сувилагчийн хийсэн асаргаа сувилгааг ээлжийн сувилагч эрчимтийн хуудсанд бичиж, тулах сувилагчаар гарын үсэг зуруулж, баталгаажуулна.

ДОЛОО. ХОРИГЛОХ ЗҮЙЛ

7.1 Хийхээр төлөвлөсөн эмчилгээ сувилгааг урьдчилан тэмдэглэхийг хориглоно.

7.2 Тухайн сувилагч өөрөө биечлэн асаргаа сувилгаа, эмчилгээ хийгээгүй бол бусдын өмнөөс тэмдэглэгээ хийхийг хориглоно.

7.3 Хийсэн асаргаа сувилгаатай хамааралгүй зүйлсийг бичиж тэмдэглэхийг хориглоно.

7.4 Алдаатай гэж бичсэн зүйлээ баллах, арилгагч хэрэглэхийг хориглоно. Алдаатай бичсэн бичсэн зүйлсийн доогуур зурж тэмдэглэн, залруулгыг бичнэ.

7.5 Амархан арилах бал харандаагаар бичиж тэмдэглэхийг хориглоно.

7.6 Тэмдэглэлийн дунд хоосон зай мөр орхихыг хориглоно.

НАЙМ. ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭ

8.1 Тасгийн ахлах сувилагч нар нь өдөр тутамдаа сувилгааны түүх хөтлөлт, сувилгааны маягт хөтлөлт хянах, зөвлөмж өгөх,

8.2 Тасаг бүрийн өөрийн онцлогт тохирсон төрөлжсөн сувилахуйн тусламж үйлчилгээг үзүүлдэг байх

8.3 Сувилахуйн албанаас 7 хоног бүр сувилгааны түүх хөтлөлт болон сувилгааны маягт хөтлөлтөнд үнэлгээ өгөн цаашид анхаарах, сайжруулах асуудлыг тасгийн эрхлэгч САЗ-д мэдээлнэ.

8.4 Сувилахуйн албанаас сувилагч, эх баригч нартаа сувилгааны түүх хөтлөлт, сувилгааны маягт хөтлөлт, эх барихын хяналтын хуудас хөтлөлтийн сургалтыг зохион байгуулах

НАЙМ. ЖИШИГ СУВИЛГААНЫ ТҮҮХ

СУВИЛГААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Эмчлүүлэгчийн овог нэр : Г.Х Өвчний түүхийн № 1462 нас: 65 хүйс: эм тасаг :
ЭЭТасаг Өрөө: 10

Асуудлын дугаар	Сувилах төлөвлөгөө	Сувилгааны хэрэгжүүлэлт
<p>#1 Амьсгалах хэв маягийн өөрчлөлт # 2 Хийн солилцоо алдагдал</p>	<p>Зорилго: Захын судасны хүчилтөрөгчийг нэмэгдүүлэх</p> <p>Ажиглалтын төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Амьсгаадалтыг ажиглах - Захын судсанд хүчилтөрөгчийн хангамжийн тодорхойлох - Хүчилтөрөгчийн аппаратны хэвийн үйл ажилгаа болон хүчилтөрөгчийн гуурсны бүрэн бүтэн байдлыг үнэлэх - Хүчилтөрөгчийн шугамаар хангалттай ирж байгааг үнэлэх - Амьсгалын аппаратны хэвийн үйл ажилгааг хянах - Амьсгалын хүрээ болон фильтр , ууршуулагчийн хэвийн байдлыг үнэлэх <p>Хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Цээж өндөрлөх - Өрөөг агааржуулах - Харшил төрүүлэгч хүчин зүйлээс хол байлгах - Интубацийн гуурсаа хазах, цэр салст, цусаар бөглөрсөн эсэхийг үнэлэх - Хүчилтөрөгчийг хамрын ац гуурсаар өгөх - <p>Эрүүл мэндийн боловсрол олгох төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Амьсгалын дасгалыг зааж өгөх - Хоололтын зөвлөгөөг өгөх - Хувцаслалтын зөвлөгөөг өгөх 	<ul style="list-style-type: none"> - Амин үзүүлэлтийг цаг тухай бүрт үзэж тэмдэглэх / СТ -01 / - Хүчилтөрөгчийг хамрын ац гуурсаар, маскаармл/цагаар..... минут,цаг тутамд өгөв - Хүчилтөрөгчийн болон амьсгалын аппаратны чийгшүүлэгчийн нэрмэл усыг..... цагт сольж.....уусмалаар ариутгасан - Интубацийн гуурсны бэхэлгээг хийж, трубка дотуур болон гадуур соруулга хийсэн. Трубкины бэхэлгээ №.... байна. - Соруулга хийгдэхэд гарсан биологийн шингэний өнгө хэмжээ гарав - Цээжийг ...-т өндрлөж өгөв - Өрөөгцагт минут агааржуулав - Амьсгал авалт гаргалтын дасгалыг зааж өгөх - Уураг амин дэм, кали, кальцаар баялаг байх - Хоололтын байдал, хоолны төрөл,

	<ul style="list-style-type: none"> - Сахиурь асаргаа сувилгааны зөвлөгөө өгөх 	<ul style="list-style-type: none"> давтамжинд хяналт тавих - Хөвөн даавуун материалаар хийгдсэн өмсөж тайлахад хялбар өмд цамцтай байх - Гутал нь хөлд эвтэйхэн, оймс бариу биш байх - Сахиурт асаргаа сувилгаа хоололтын талаар зөвлөгөөг өгөх
<p>#3 Амьсгалын замын бөглөршил</p>	<p><u>Зорилго:</u> Цэр салстын өнгө үнэр хэмжээг тодорхойлох</p> <p>Ажиглалтын төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Цэрний өнгө, үнэр, хэмжээ болон цус идээ байгаа эсэхийг сайтар ажиглаж цаг тухайд нь эмчид мэдээллэх <p>Хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Цээж өндөрлөх - Өрөөг агааржуулах - Цэрээ хаях цэвэр тагтай сав бэлтгэж өгөх - Цээжинд доргиох массаж хийх / гударган байрлалд хэвтүүлэх - Цэрээ залгихгүй тогтмол гаргах - Өтгөн залхаг ихтэй идээтэй цэр гарч байгаа үед амыг бүлээн усаар зайлуулах - Амаар шингэн зүйлийн бага багаар уулгах - Цэрээ гадагшлуулж чадахгүй байгаа үед соруулга хийх - Амны хөндийн соруулга хийх - Отсосыг халдваргүйжүүлэх - Амны хөндийн угаалга хийх 	<ul style="list-style-type: none"> - цагт,цагуудад млөнгөтэй..... цэр гарав - Цэрний савыгцагтуусмалаар халдваргүйжүүлсэн - Цээжийг ...-т өндрлөж өгөв - Өрөөг цагт минут агааржуулав - цагт амыгуусмалаар удаа зайлав - Уураг амин дэм, кали, кальцаар баялаг байх - Хоололтын байдал, хоолны төрөл, давтамжинд хяналт тавих - Хөвөн даавуун материалаар хийгдсэн өмсөж тайлахад хялбар өмд цамцтай байх - Гутал нь хөлд эвтэйхэн, оймс бариу биш байх

	<p>Эрүүл мэндийн боловсрол олгох төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Цэрээ зөв гаргах талаар зааж өгөх - Хоололтын зөвлөгөөг өгөх - Хувцаслалтын зөвлөгөөг өгөх - Сахиурт асаргаа сувилгааны зөвлөгөө өгөх - Тамхи татахгүйбайхыг зөвлөх 	<ul style="list-style-type: none"> - Сахиурт асаргаа сувилгаа хоололтын талаар зөвлөгөөг өгөх -цагт соруулга хийж өнгөтэй..... мл гарав - Шаардлагатай тохиолдол бүрт удаа соруулга хийв - Амны хөндийг удаа угаав. удаа халдваргүйжүүлэх уусмалаар халдваргүйжүүлэв.
<p># 4 Хөдөлгөөний алдагдал</p>	<p>Зорилго: Хөдөлгөөний алдагдлаас сэргийлэх</p> <p>Ажиглалтын төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Мөчдийн хөдөлгөөний далайцыг тодорхойлох - Өөрт эвтэйхэн байх байрлалыг сонгох - Ортезыг бэлэн байлгах <p>Хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Цээж өндөрлөх - Өрөөг агааржуулах - Байрлалыг 2 цаг тутамд сэлгэх - Ивүүр болон будааг хийж өгөх - Хөл болон гарт иллэг массаж хийж өгөх / үений далайцаар хөдөлгөх - Шээсийг хэмжиж асгах савыг бэлтгэх <p>Эрүүл мэндийн боловсрол олгох төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Хоололтын зөвлөгөөг өгөх - Хувцаслалтын зөвлөгөөг өгөх - Сахиурт асаргаа сувилгааны зөвлөгөө өгөх 	<ul style="list-style-type: none"> - цаг тутамд байрлалыг сэлгэв -цагт иллэг массаж хийж тослож өгөв - Үений далайцаар хөдөлгөн дасгал хийхийш сахиурт зааварлав. - Уураг амин дэм, кали, кальцаар баялаг байх - Хоололтын байдал, хоолны төрөл, давтамжинд хяналт тавих - Хөвөн даавуун материалаар хийгдсэн өмсөж тайлахад хялбар өмд цамцтай байх - Гутал нь хөлд эвтэйхэн, оймс бариу биш байх - Сахиурт асаргаа сувилгаа хоололтын талаар зөвлөгөөг өгөх -цагт соруулга хийж өнгөтэй..... мл гарав

		<ul style="list-style-type: none"> - Шаардлагатай тохиолдол бүрт удаа соруулга хийв
<p>#5 Ядаргаа</p>	<p>Зорилго: Үйлчлүүлэгчийн хэт ядралтаас сэргийлэх</p> <p>Ажиглах төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Нийгмийн байдал, ажил эрхлэлт, гэр бүлийн байдал зэргийг тодорхойлох - Орны ая тухыг хангах, өрөөнд агаар оруулах <p>Хэрэгжүүлэх төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Бүх биеийн угаалга хийх - Ваннтай усанд хэвтүүлэх - Бүх биед иллэг хийх - Гар хөлийг чийгтэй алчуураар арчих <p>Эрүүл мэндийн боловсрол олгох төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Ажил амралтаа зохицуулах - Амьдралын хэв маягаа өөрчлөх талаар зөвлөх, ярилцах 	<ul style="list-style-type: none"> - Өрөөг өөрт тухтай орчин нөхцлийн бүрдүүлэх - Өрөөнд цагт минут агаарын сэлгэлт хийв - цагт бүх биеийн угаалга хийж өгөв. - Бүх биед иллэг цагт хийж өгөв. - Гар хөлийг ... цагт иллэг массаж хийж өгөв - амьдралын хэв маягийн талаар зөвлөгөөг өгөв.
<p>#6 Цусны эргэлтийн алдагдал</p>	<p>Зорилго : Цусны эргэлтийн алдагдал</p> <p>Ажиглалтын төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Захын судсандахь хүчилтөрөгчийн хангамжийг хянах - Мөчдөөр болон хэсгээр хавантай эсэхийг үнэлэх - Холголт цооролт дарагдал үүсэх эрсдлийг хянах - Амин үзүүлэлтийг тогтмол үзэх <p>Хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Хялгасан судасны хүчдэл дүүрэлтийг хянах - Цээжийг өндөрлөх - Шаардлагатай тохиолдолд байрлалыг тогтмол сэлгэх - Шээсийг хэмжиж асгах шингэний баланс хөтлөх 	<ul style="list-style-type: none"> - Мониторт холбож амин үзүүлэлтийг тогтмол хянав - Жинг үзэв - Байрлалыг цаг тутамд сэлгэв - Цээжийг хэмд өндөрлөв - Шээсийг хэмжиж асгав. Хоногийн шээс ... мл баланс/ / байв. - Чанаж жигнэж болгосон хагас шингэн хоолыг өдөрт 3-4 удаа бага багаар идэхийг зөвлөв - Амаар уух шингэнийг бага багаар уух

	<p>Эрүүл мэндийн боловсрол олгох төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Хоололтонд хяналт тавих - Шингэн уух зүйлийг хянаж уулгах - Хувцаслалтын зөвлөгөө өгөх - Сахиурт болон ар гэрийнхэнд шинж тэмдэгийн асаргаа сувилгааны зөвлөгөө өгөх 	<p>хоногт уух шингэн ... мл байна.</p> <ul style="list-style-type: none"> - Хөвөн даавуун материалаар хийгдсэн өмсөж тайлахад хялбар өмд цамцтай байх - Гутал нь хөлд эвтэйхэн, оймс бариу биш байх - Сахиурт асаргаа сувилгаа хоололтын талаар зөвлөгөөг өгөх
<p>#7 Шокын эрсдэл</p>	<p>Зорилго: Амин чухал эрхтнүүдийн хэвийн үйл ажиллагааг хянах</p> <p>Ажиглах төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Амин үзүүлэлтийн тогтмол хянах - Глазго үнэлгээг хийх <p>Хэрэгжүүлэх төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Гол судсанд уян зүү тавих - Мониторт холбож амин үзүүлэлтийн хянах - Цээж шахахад бэлтгэх - Амь тэнссэн үеийн тусламж үйлчилгээнд бэлтгэх / амбу, маск, ларингоскоп, интубацийн гуурс, 10 граммын шприц, бэхэлгээ хийх наалт, хүчилтөрөгчийн аппарат, хүчилтөрөгчийн гуурс, эм тарианы нөөцийг бүрэн бэлтгэх / 	<p>Амин үзүүлэлтийг ... цээжний холболт хийн .. тутамд амин үзүүлэлтийг үзэв</p> <ul style="list-style-type: none"> - Үйлчлүүлэгчийн биеийн байдлыг үнэлэн Глазго байв - ... G уян зүүг гар, хөлд тавьж бэхлэв. - Амь тэнссэн үед хийгдсэн эмчилгээ амилуулах үйл ажилгаа бүрийг бичиж тэмдэглэх
<p>#9 нойр хулжих # 10 нойргүйдэл</p>	<p>Зорилго: Сайн унтуулах тайван байдлыг хангах</p> <p>Ажиглах төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Өдрийн аль цагт унтаж байгааг ажиглах 	<p>Унталтын байдалд хяналт тавих цагт байдалтай унтаж байв</p>

	<ul style="list-style-type: none"> - Нойрсолтын байдал гүн байна уу? Сэрвэгнээд унтаж чадахгүй байна уу ? - Сэтгэл санааны зовнил болон биеийн байдлыг үнэлэх <p>Хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Нойрсуулах болон тайвшруулах эмчилгээг эмчийн заалтын дагуу хийх - Өрөөг тохилог болгох - Агааржуулалт хийх - Аль болох үйлчлүүлэгчид таатай орчин бүрт зөвлөгөө өгөх <p>Эрүүл мэндийн боловсрол олгох төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Биед иллэг массаж хийж өгөх - Хөлийг бүлээн усанд дүрэх - Хувцаслалтын талаар зөвлөгөө өгөх - Хоололтын зөвлөгөөг өгөх - Сахиурт болон ар гэрийнхэнд зөвлөгөө өгөх 	<p>Өрөөг минутанд салхивч цонх нээж агааржуулав.</p> <p>Хөвөн даавуун материалаар хийгдсэн өмсөж тайлахад хялбар өмд цамцтай байх</p> <p>Гутал нь хөлд эвтэйхэн, оймс бариу биш байх</p> <p>Үйлчлүүлэгчид унтахад таатай орчинг бүрдүүлэх / хөл гарт нь иллэг массаж хийж өгөх, хөлийг бүлээн усанд дүрэх /</p>
<p># 11 Хөдөлгөөн муудсан</p>	<p>Зорилго: хөдөлгөөн алдагдлаас сэргийлэх</p> <p>Ажиглалтын төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Үйлчлүүлэгчийн хөдөлгөөн алдагдлыг харж ажиглах, өөрөө юу хийж чадах талаар асууж хөдөлгөөний идэвхийг үнэлэх - Үений далайцын үнэлгээг гаргах <p>Хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Байрлалыг 2 цаг тутамд солих - Гар хөлд иллэг массаж хийх - Туслах хэрэгслийн хэрхэн зөв хэрэглэх талаар зааж сургах 	<ul style="list-style-type: none"> - Хөдөлгөөн алдагдлыг үнэлэхэд байдалтай байна. - Өөртөө үйлчлэх чадвар байна. - Үений далайцыг тодорхойлоход байв. - Байрлалыг цаг тутамд сольв. цагт ивүүр болон... хөл гарын байрлалыг сэлгэв.

	<ul style="list-style-type: none"> - Саатай болон хөдөлгөөн муудсан талын гар хөлийн том жижиг дэрний тусламжтайгаар үйлчлүүлэгчийн ая тухтай байдлыг ханган зөв байрлуулах - Суугаа үед шилбэнээс дээш ивүүр, сандал тавьж, үе мөч тэнийлгэх дасгал хөдөлгөөн хийлгэх - Зураг зуруулж тоглоом тоглуулах <p>Эрүүл мэндийн боловсрол олгох төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Асран хамгаалагчид асаргаа сувилгааны зөвлөгөө өгөх / орноос тэргэнцэр лүү, эргүүлэх, орны гол руу болгох, хоол/ тээвэрлэх талаар арга техникийг асран хамгаалагчид зааж сургах 	<ul style="list-style-type: none"> - цагт иллэг хийж тосоор массаж хийж өгөв. - Асран хамгаалагчид өдөр тутмын асаргаа сувилгааны / орноос тэргэнцэр лүү, эргүүлэх, орны гол руу болгох, хооллох, ярилцах, ойлнолцохо сургах /
<p>#13 Амны салст бүрхүүлийн гэмтэл</p>	<p>Зорилго: Амны хөндийн зовиурыг эрт арилган, халдварт өртүүлэхгүй байх арга хэмжээ авах</p> <p>Ажиглах төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Амны салс бүрхүүлийг өнгө, шархны хэмжээ хоолойг ажиглана - Эвгүй үнэр байгааг шалгах <p>Хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Амны хөндийг байнга чийглэх - Бүлээвтэр устай шүршүүрээр шүрших - Мөс хүлхүүлэх / бөөрөнхий байх/ - Натри, новокайн, содын уусмалын аль нэгээр зайлуулна. 	<ul style="list-style-type: none"> - Амны хөндийн шарх, өнгө , шархны хэмжээ, өнгөрийг харах - Хоолойг ажиглах / улайсан, идээлсэн, хоолойны махтай эсэхийг үнэлэх / - Амны хөндийг цагт ... уусмалаар цаг тутамд зайлуулж, хөвөнн бөмбөлөг, ариун шарик, марль самбай ашиглан цэвэрлэж өгөв. - Амны хөндийд эмийг ... цагт цацаж өгөв. - Амны хөндийг угаахдаа зөөлөн үстэй

	<ul style="list-style-type: none"> - Амны хөндийг тамединаар зориулалтын савх ашиглан цэвэрлэх - Эмчийн заалтаар эмийн бодисыг цацах буюу уулгах - Гарсан үр дүн өөрчлөлтийн талаар арга хэмжээг авах <p>Эрүүл мэндийн боловсрол олгох төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Хэт халуун, хүйтэн хоол идэхгүй байх - Халуун ногоо хийжүүлсэн ундаа, нимбэгний шүүс хэрэглэхгүй байх - Хагас шингэн хоол идэх - Зөөлөн үстэй сойз хэрэглэх - Амны хөндий болон шүдээ байнга цэвэрлэх зөвлөгөөг өгөх 	<p>сойзыг хэрэглэх, хэв чанга дарж, үрж угаахгүй байхыг зөвлөв.</p> <p>Хэт халуун, хүйтэн хоол идэхгүй байх Халуун ногоо хийжүүлсэн ундаа, нимбэгний шүүс хэрэглэхгүй байх Уураг болон витаминаар баялаг хагас шингэн хоолыг өдөрт 3-4 бага багаар ойр ойрхон идэх</p>
<p>#14 Хоол тэжээлийн алдагдал:бие махбодийн хэвийн хэмжээнээс их</p>	<p>Зорилго: Хэрэгцээ, хэрэглээнд тохирсон хоол тэжээлийн тэнцэрийг барих</p> <p>Хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Хоолны найрлага болон хооллох цагийг тохируулах - Бүх бие шарлалттай, загатнаатай бол бүлээн усаар арчих, тослож өгөх <p>Эрүүл мэндийн боловсрол олгох төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Амны хөндий арчилгаа болон хумсны ариун цэврийн талаар зөвлөгөө өгөх - Биеийн жин хасахад хувь хүнд зориулсан хоолны төлөвлөгөө чухал гэдгийг үйлчлүүлэгчид ойлгуулах - Үйлчлүүлэгчийн нүүрстөрөгч агуулсан хүнсний бүтээгдэхүүн, өөх тостой хоолны хэрэглээ болон нэг төрлийн хоол удаан идэхээс 	<ul style="list-style-type: none"> - Өдөр тутмын хоолны найрлагыг хоол зүйч эмчээс зөвлөгөө авах - Өөрт тохирсон дасгал хөдөлгөөнийг зааж өгөх - Идэвхитэй амьдралын хэв маягийн талаар сурталчилах - Сойзыг зөөлөн үстэйг сонгох, шүдээ угаахдаа зөөлөн угааж буйлыг гэмтээхгүй байх, биеийг чийгтэй

	<p>үүсэх дарамтыг багасгах, гэхдээ хориглоогүй бусад хүнсний хэрэглээг нэмэгдүүлэх</p> <ul style="list-style-type: none"> - Үйлчлүүлэгчид зориулсан хоолны төлөвлөгөө зохиох. Бодисын солилцоог хэвийн байлгаж, цусандах глюкозыг хэдэн сар амжилттай бууруулснаар үйлчлүүлэгчийн биеийн жинг 10%-иар буулгана. - Амьдралын хэв маягаа өөрчлөхөд нь дэмжих - Биеийн жин асах дасгал хөдөлгөөний тухай тайлбайрлах - Хоол хүнсээр авсан илчлэгийг шатаахад туслах дасгалыг зааж өгөх - Хоолны дуршил бодисын солилцооноос нэмэгдүүлэх хэрэглээнээс зайлсхийх - 	<p>алчуураар арчиж, тослохыг зөвлөв.</p> <p>-</p>
<p>#15 Хоол тэжээлийн алдагдал:бие махбодийн хэвийн хэмжээнээс бага</p>	<p>Зорилго:</p> <ul style="list-style-type: none"> - Хоол тэжээлийн тэнцвэр алдагдлыг тодорхойлох <p>Ажиглалтын төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Хоол тэжээлийн дутагдалтай эсэхийг үнэлэх - Хоололтын байдал болон эргэлтийн хоолонд хяналт тавих <p>Хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - 1 удаа идэх хоолны хэмжээг багасгах, давтамжийг нэмэгдүүлэх - Хоол зүйчээс зөвлөгөө авах - Эмчлүүлэгчийн суугаа байрлалд өгөх - Сувилагч өөрөө гардан хооллох 	<ul style="list-style-type: none"> - Биеийн жингийн индексийг тодорхойлох - Илчлэг, уураглаг, амин дэмээр баялаг, жигнэж чанаж болгосон хоолыг өдөрт бага багаар ойр ойрхон өгөх - ... цагт ... гр хоолыг хагас суугаа байрлалд өгөв. - Өдөр тутмын хоолны найрлага, амин дэм

	<ul style="list-style-type: none"> - Биед тохирсон иллэг массажийг хийж өгөх <p>Эрүүл мэндийн боловсрол олгох төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Эмчлүүлэгчийн ар гэрийнхэнд эмчлүүлэгчийн хоолны талаар зөвлөгөө өгөх - 19 цагаас хойш хоол идүүлэх - Жижиглэж ууранд болгосон хоол өгөх - Хоолны өнгө үнэр амтанд хянах. 	<p>илчлэг сайтай хоол хүнсийг хоол зүйч эмчээс зөвлөгөө өгнө.</p> <p>-</p>
<p>#16 Залгих чадварын алдагдал</p>	<p>Зорилго: залгих чадварын алдаглыг сэргээх</p> <p>Ажиглалтын төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Хоол тэжээлийн дутагдалтай эсэхийг үнэлэх - Залгих чадварыг үнэлэн, бөглөрөх эрсдлээс сэргийлэх <p>Хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Үйлчлүүлэгчийн ерөнхий байдалыг хянах - Үйлчлүүлэгчийг хагас суугаа байрлалд сууж хооллох - БЖИ-г тодорхойлох - Цээжийг өндөрлөх - Эмчийн заавраар эмчилгээний хоолоор хооллох - Ходоодонд зонд тавих - Соруулгын гуурсыг цэвэрлэх - Хөдөлгөөн засалчийн зөвлөгөө авах <p>Эрүүл мэндийн боловсрол олгох төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Хоололтын зөвлөгөөг өгөх - Хувцаслалтын зөвлөгөөг өгөх - Сахиур асаргаа сувилгааны зөвлөгөө өгөх 	<ul style="list-style-type: none"> - Биеийн ерөнхий байдалд үнэлгээ өгөх - Биеийн жингийн индексийг тодорхойлоход ... байв. - Цээжийг өндөрлөв. - Зажлалт багатай зөөлөн шингэн хоол, зутан хэлбэрийн хоол, уураг , илчлэг, витаминлаг амин дэмээр баялаг байх - Хоололтын байдал, хоолны төрөл, давтамжинд хяналт тавив. - Соруулга хийгдэхэд гарсан биологийн шингэний өнгө хэмжээ гарав - Ходоодонд зондыг цагт тавив. - Хөвөн даавуун материалаар хийгдсэн өмсөж тайлахад

		<p>хялбар өмд цамцтай байх</p> <ul style="list-style-type: none"> - Сахиурт болрн ар гэрийнхэнд Үйлчлүүлэгчийг хагас суугаа байрлалд гардан хооллох зөвлөгөөг өгөв.
<p>#17 Бөглөрөх эрсдэл</p>	<p>Зорилго: Бөглөрөх, хахах эрсдлээс сэргийлэх</p> <p>Ажиглалтын төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Бөглөрөлт үүсгэсэн хүчин зүйлийг тодорхойлох - Бөөлжис цутгах бөөлжих эрсдэл байгаа эсэхийг тодорхойлох - Бөөлжилт хэмжээ, өнгө / гарч байгаа зүйлд анхаарах/ ажиглах <p>Хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Цээж өндөрлөх - Амыг цэвэр усаар зайлуулах - Бөөлжисөөр гарч байгаа зүйлийн өнгө, хэмжээ, хэлбэрийг ажиглах - Тагтай сав бэлтгэж өгөх, - Шингэний балансыг тооцох - Шаардлагатай тохиолдолд соруулга хийх <p>Эрүүл мэндийн боловсрол олгох төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Сахиурт болон ар гэрийнхэнд цээж өндөр байлгахыг зөвлөх - Хурц үнэр амттай, махтай хоолыг хориглох - Бага багаар хагас шингэн хоол идэхийг зөвлөх - 	<ul style="list-style-type: none"> - Цээжийг хэмд өндөрлөж өгөв - Бөөлжилт бүрийн дараа амыг цэвэр усаар зайлуулав - цагт хэмжээтэй өнгөтэй бөөлжсөн. - <i>Бөөлжисийг тагтай саванд хийж асгаж, халдваргүйжүүлэх уусмалаар халдваргүйжүүлэв. . Шингэний балансыг тооцож, өдөр тутамдаа жинг үзэхэд байв.</i> - Сахиурт асаргаа сувилгаа хоололтын талаар зөвлөгөөг өгөх -цагт соруулга хийж өнгөтэй..... мл гарав - Шаардлагатай тохиолдол бүрт удаа соруулга хийв
<p># 18 Бөөлжис цутгах</p>	<p>Зорилго: Бөөлжилт намдаах</p> <p>Ажиглалтын төлөвлөгөө:</p>	<ul style="list-style-type: none"> - Бөөлжилт нь өдөртудааөнгөтэй зүйлээр бөөлжив.

	<p>Хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> -Бөөлжисний өнгө хэмжээнд үнэлгээ өгөх -Бөөлжих огиход нь туслах -Тусгай сав бэлтгэж эмчлүүлэгчийн ойр тавих -Амыг зайлуулах -Аюулхай орчим бүлээн жин тавих -Ам арчих алчуур бэлдэж өгөх -Бүлээн ус уулгах <p>Эрүүл мэндийн боловсрол олгох төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Хоололтын зөвлөгөөг өгөх - Хувцаслалтын зөвлөгөөг өгөх - Сахиурт асаргаа сувилгааны зөвлөгөө өгөх 	<ul style="list-style-type: none"> - Хоололтын байдал, хоолны төрөл, давтамжинд хяналт тавих - Бөөлжисны савыг%уусмалаар ариутгаж халдваргүйжүүлэв. - Бүлээн жинг ...градус,10-15 мин тавив. - Амыг амыг физиологийн уусмалаар зайлуулав. - Сахиурт асаргаа сувилгаа хоололтын талаар зөвлөгөөг өгөх
<p># 19 Шингэний хэмжээ ихсэлт</p>	<p>Зорилго:</p> <ul style="list-style-type: none"> - Биедэх шингэний хэмжээг хэвийн хэмжээд барих <p>Ажиглалтын төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Арьсны уян хатан байдлыг тодорхойлох <p>Хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Хоногт хэрэглэж байгаа шингэний хэмжээг тооцоолох - Биеийн жинг өдөр бүр үзэх - Хөлийг өндөрлөх - Хөл гарт иллэг хийх - Хөлийг чийгтэй алчуураар арчих <p>Эрүүл мэндийн боловсрол олгох төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Хоололтын зөвлөгөөг өгөх - Хувцаслалтын зөвлөгөөг өгөх - Сахиурт асаргаа сувилгааны зөвлөгөө өгөх 	<ul style="list-style-type: none"> - Хоногийн шингэний балансыг тооцоход байв. - Биеийн жинг үзэхэд байв - Хөлийг хэмд өндөрлөв. - Хөл гарт иллэг массажийг цагт хийж өгөв. - Хоол зүйч эмчээс зөвлөгөө авч өдөр тутмын хоололтонд хяналт тавив. - Хөвөн даавуун материалаар хийгдсэн өмсөж, тайлахад хялбар бие бариагүй резингүй байх

<p>#20 Шингэний дутагдал</p>	<p>Зорилго: Биедэх шингэний хэмжээг хэвийн хэмжээд барих</p> <p>Ажиглах төлөвлөгөө</p> <ul style="list-style-type: none"> - Арьсны уян хатан чанар, халуун, чийгшилт, өнгийг ажиглах <p>Хэрэгжүүлэх төлөвлөгөө</p> <ul style="list-style-type: none"> - Амин үзүүлэлт болон шээсний гарцын хянах - Биеийн жин, хэвлийн тойргийг өдөр бүр үзэх - Өтгөний өнгө хэмжээ, бүтэц, тогтоцыг ажиглах - Бүтэн биеийн угаалга хийх <p>Эрүүл мэндийн боловсрол олгох төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Амаар шүлтлэг шингэн, мениралус, содын суурилсан уусмал өгөх - Хоногт хэрэглэх амин дэм, эрдэс бодисын хэмжээг тогтоох 	<ul style="list-style-type: none"> - Арьсны байдалд цагт үнэлгээ өгөв. Арьсны шинж байдал байв. - цагт амин үзүүлэлтийг хянав. - Хоногийн шээсний гарцыг хянав..... мл байв. - Биеийн жин байв - Хэвлийн тойрог байв. - -амаар уух шингэнийг бага багаар уухыг зөвлөв - Бүтэн биеийн угаалга хийж тослож өгөв. - Хоногт илчлэг, амин дэмээр баялаг хоолыг өдөрт 3-4 удаа идэхийг зөвлөв.
<p>#21 өтгөн хаталт</p>	<p>Зорилго: Өтгөн хаталтаас сэргийлэх</p> <p>Ажиглах төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Гэдэс цардагар дүүрэнгэ байгааг ажиглах - Өвчтнийг ажиглах, хэвлийд үзлэг хийх <p>Хэрэгжүүлэх төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Өтгөний хэмжээ, давтамж, өнгө, хэлбэрт үнэлгээ өгөх - Гэдэсний гүрвэлзэх хөдөлгөөн сайжруулах дасгал хийлгэх - Гэдсэнд иллэг хийх - Цэвэрлэх болон бичил бургуй тавих - Хэд хоноод өтгөнөөр бие зассаныг лавлаж асуух 	<ul style="list-style-type: none"> - Өтгөний хэмжээ хэлбэр өнгө байв. - Гэдэсний гүрвэлзэх хөдөлгөн сайжруулах дасгалыг зааж өгөв. - Хүйсийг тойруулан нар зөв өдөрт удаа, минут хугацаатай иллэг хийв - Цэвэрлэх бургуйг цагт тавив. Өтгөн мл гарав. Хэлбэр, хэмжээ байв. - Бичид бургуйг цагт тавихад өтгөн хэмжээтэй гарав.

	<ul style="list-style-type: none"> - Байрлалыг сэлгэж түрүүлгэ харуулах <p>Эрүүл мэндийн боловсрол олгох төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Зөв бие засах , халдварас сэргийлэх талаар зөвлөгөө өгөх - эслэг ихтэй хоол хэрэглэхийг зөвлөх - амаар бүлээн шингэн зүйл бага багаар уухыг зөвлөх - Хоололтын зөвлөгөөг өгөх 	<ul style="list-style-type: none"> - Байрлалаа сэлгэж хэвтэх талаар зөвлөв. /Түрүүлгэ харж хэвтэх / - Зөв бие засах талаар хэт дүлэхгүй байх, удаан хугацаагаар дүлж суухгүй байхыг зөвлөв. - Бие зассан дараа хошног орчмын бүлээн усаар угаах, гарыг угаахыг зөвлөв. - Өдөрт уух шингэний хэмжээг ихэсгэх, бор гурил, байцаа, бүхэл үрийн гурил будааг хэрэглэхийг зөвлөв. - Хүнсний ногоо жимс жимсгэнэ банана зэргийг идэх
<p># 22 Суулгалт</p>	<p>Зорилго: Суулгалтын хэмжээг ажиглан, суулгалтыг хэмжээг тодорхойлох,</p> <p><u>1.Ажиглах төлөвлөгөө:</u></p> <ul style="list-style-type: none"> -Ухаан санаа байдлыг ажиглах -Өтгөний өөрчлөлтийг ажиглах - -Арьс хуурайших -Арьсны уян хатан чанар <p><u>2.Хэрэгжүүлэх төлөвлөгөө:</u></p> <ul style="list-style-type: none"> -Амин үзүүлэлт хянах -Өтгөний агууламжийг хэмжих -Өтгөний хэмжээг хянах -Суулгалтын давтамжийг хянах -амаар шингэн уулгах -шингэний баланс хөтлөх -хөтөвч , суултуур бэлтгэж тавьж өгөх -Суулгалт бүрийн дараа хувийн а/ц сахиулах 	<p>Ухаан санааг үнэлж ажиглах унтаарсан байдалтай, нүд сүүмгэр, уйлагнасан, уцаартай, цонхийсон байдалтай гэх мэт</p> <p>Өнгө шар, бор, хар г,м үнэр хурц басс үнэртэй , үнэргүй г,м хэлбэр усан усархаг, өтгөн, лаглагар, г,м хэмжээ их, бага хэвийн г,м ийг ажиглаж тэмдэглэх</p> <p>Арьсны байдлыг ажиглаж, арьсны уян хатан чанар алдагдсан, алдагдаагүй, арьс хуурайшсан, чийглэг байгааг хянаж тэмдэглэнэ</p>

	<p><u>3.ЭМБО төлөвлөгөө:</u></p> <p>-Орчин -Хооллолт -Хувцаслалтын зөвөлгөө өгөх</p>	<p>Амин үзүүлэлтүүдийг цаг тутамд үзэхэд байна амин үзүүлэлт тогтвортой , тогтворгүй хэмжлэг хэрэгтэй хэрэггүй гэх мэт Өтгөний агууламжийг хянахад цустай, цусархаг, хөөстэй , хөөсөрхөг хоол боловсорсон, хоол боловроогүй,.....гр, өдөрт ... удаа, шөнөдөө удаа суулгасан Амаар суулгалт бүрийн дараа,минутын давтамжтай ,зайтай,халбагааргр-аар,аягаар, өдөртгр, өдөртл уулгахад биеийн байдал сайжирсан , сайжрал аваагүй , дордсон, байна. Г.м Шингэний баланс хөтлөж ө/ түүхэнд хавсаргав Суулгалт бүрийн дараа бөгсөн биеийг угааж гарын ариун цэвэр сахиулж угаалгав</p> <p>Агаарын солилцоо сайн, гэрэлтүүлэг сайтай, цэвэр дулаан байх</p> <p>Амаар шингэн уулгах, давс сахарын уусмал, хорсол , будааны шүүс гэх мэт өдөрт удаагр ,халбага хэмжээгээр уулгах зөвлөмж өгөх</p>
--	---	---

		<p>Хөвөн даавуун хөнгөн дулаан биед эвтэйхэн хувцас өмсүүлэх Дотуур хувцасыг 2-3 ээлж байхаар бэлтгэх зөвөлгөө өгнө. -Хөтөвчин дээр удаан суух үед жийрэг даавуу дэвсэж өгөв</p>
<p># 23 Агаарын солилцооны алдагдал</p>	<p>Зорилго: Амьсгалын замын саадыг ажиглах 1.Ажиглах төлөвлөгөө: - захын болон төвийн хөхрөлт байгаа эсэхийг хянах - амьсгалын замын саад байгаа эсэхийг ажиглах 2.Хэрэгжүүлэх төлөвлөгөө: - Амин үзүүлэлтүүд хянах - SPO2 хянах - хүчилтөрөгч чийглэж өгөх -өрөөг агааржуулах 3.ЭМБО төлөвлөгөө: -Орчин -Хооллолт -Хувцаслалтын зөвөлгөө өгөх</p>	<p>Хамар, амын гурвалжин хөхөрсөн, хөрсөн, нүүр хөхөрсөн, хөхөлбөр, гар хөлийн үзүүр хөхрөх, хөрсөн, амьсгалахад бэрхшээл байгаа эсэх амьсгаадсан, амьсгал давчидсан, эсвэл бачуурсан, хяхтансан, исгэрсэн, шуугисан ширүүн гэх, мэт Амин үзүүлэлтүүдийг хянахад байна Дахин давтан цагийн давтамжтай үзэхэд байна тогтвортой, тогтворгүй гэх мэт SPO2 = O2 –той O2-гүй байна. O2мл/цагаар давтамжтай цаг өгөхөд байна цагийн дараа тогтворжиж болсон Эсвэл дээрдээгүй байна дахин дараа хянах</p>

		<p>Өрөөг тогтмол агааржуулах агаарын сэлгэлтийг цаг тутамд хийнэ.</p> <p>Дээрхи үр дүнд биеийн байдал болсон гэх мэт</p> <p>Агаарын солилцоо сайтай, саруулхан , чимээ шуугиан багатай байна</p> <p>Илчлэг уураг сайтай хагас шингэн байдалтай халуун бүлээн хоолыг бага багаар өдөрт 4-6 удаа хооллоно</p> <p>Нимгэн хөвөн даавуун материалтай чийг татдаггүй өмсөхөд эвэйхэн задгай энгэртэй өмд цамц байвал зүгээр</p> <p>Орчин хоол, хувцаслалтын талаар сахиур болон ар гэрт зөвөлгөө өгөх шаардлагатай</p> <p>Мөн орны цагаан хэрэглэл хөвөн даавуун биед ямар нэг харшил өгөхгүй зөөлөн байх</p>
<p># 24</p> <p>Цусандахь сахарын хэмжээ тогтворгүйжих эрсдэл</p>	<p>Зорилго: Цусандахь сахарыг хянах, хүндрэлээс сэргийлэх</p> <p>1.Ажиглах төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - ууж буй шингэний их багыг ажиглах - мах мариаг ажиглах -идэж буй хоолны хэмжээ, орцыг хянах -биед ил шарх байгаа эсэхийн ажиглах <p>2.Хэрэгжүүлэх төлөвлөгөө:</p>	<p>Ууж буй шингэн хоногтгр , орц найрлагашингэнийг ууж байгаа нь энэ өвчний үед хэрэглэгдэх хэмжээнд тохирч байна , тохирохгүй байна</p> <p>г.м</p> <p>.....кг жинтэйхэвлийн тойрогсм жингийн илүүдэл байгаа эсэх хэвлийн таргалалттай эсэхийг ажиглаж бичнэ.</p> <p>.....зүйлийг хориглоно, зүйлийг ямар</p>

	<p>-Амин үзүүлэлт хянах -Цусан дахь сахрын хэмжээг хянах -хөлийг үзлэг хийх -жин,өндөр , хэвлийн тойрог хэмжих, БЖИ тодорхойлох Шингэний баланс хянах</p> <p>3.ЭМБО төлөвлөгөө: -Хооллолт -Хөдөлгөөн -Хувцаслалтын зөвөлгөө өгөх</p>	<p>..... хэмжээтэй хооллож байгаа нь тохиромжтой тохиромжгүйг ажигласанаа бичнэ. Хөлийг харахад , шархтай улайсан хавдсан, идээлсэн, хөлийн хумс шигдсэн, удсан шархтай, ил шархгүй хөлийн хумс шигдээгүй цэвэр гэх мэт харсан үзсэн зүйлийг бичнэ</p> <p>--Амин үзүүлэлтүүдийгцагтхэдэн удааүзэхэд тогтвортой , тогтворгүй байгааг бичнэ. --Цусан дахь сахрын хэмжээг захын судсанд өлөн үед, хооллосоны дараа ,..... цаг тутамд үзэж хянахад ммоль хэлбэлзэлтэй, хэлбэлзээгүй, хэмжигдэхгүй эсвэл хэт өндөр, хэт буурсан гэх мэт -Хөлд үзлэг хийж шархтай хэсэгт халдваргүйтгэх уусмал хэрэглэж ариун нөхцөлд .цэвэр, тостой, ариун боолт хийж дахин боолт хийсэн болон хийх хугацааг тавьж тэмдэглэл , тандалт хөтлөж ө/ түүхэнд наасан Хөлд шархгүй үед хөлийн цусан хангамжийг сайжруулах саатал үүсэхээс сэргийлж хөлийг дээш өргүүлэх буюу өндөрлөж хэвтүүлж хөлийг сайн амраав . бүлээн усанд дүрнэ гэх мэт</p>
--	--	--

	<p>-Жинг үзэхэдкг, өндөр см хэвлийн тойрогсм БЖИ үзэхэд илүүдэл жинтэй, тохирсон, хэвлийн таргалалттай, хэвийн байлаа. Үүнийг хэвийн хэмжээнд болгохын тулд эрүүл мэндийн мэдлэг олгох шаардлагатай , шаардлагагүй , өөрөө хангалттай сайн мэдлэгтэй байна гэх мэт</p> <p>-Шингэний баланс / үнэн зөв тооцох/тооцоход /-/, /+/ баланстай балансийг тооцоод шингэний балансийн хуудсанд тэмдэглэж ө/ түүхэнд хавсаргав</p> <p>-Хооллолт ЧШӨ-ний үеийн хооллолт, дэглэм нь ойрхон , бага хэмжээтэй хооллоно. Өдөрт 5-6 удаа иднэ. Тухайн үйлчлүүлэгчийн кг/жинд тохирсон уураг, илчлэгийг нарийн мэргэжлийн эмч, сувилагч буюу хоол зүйч эмчээс зөвлөгөө авахуулах</p> <p>Хориглох зүйл: чихэр, сахар, архи, тамхи</p> <p>Хөдөлгөөн: Өдөр бүр 1удаа хийхдээ тасралтгүй 30 минутын турш дунд зэргийн ачаалалтай дасгал хөдөлгөөнийг хийлгэх</p>
--	---

		<p>Хувцаслалт: Хөвөн даавуун материалтай ус чийг шингээдэг, задгай энгэртэй өмсөж тайлахад хялбар, биед эвтэйхэн чөлөөтэй, цайвар өнгийн хувцас өмсөх Гутал хэт бариу, хэт том биш байх, зөөлөн , нам ултай хальтардаггүй байх</p>
<p>#25 Шээс алдалт</p>	<p>Зорилго: Шээс алдаж буй шинж тэмдгийг арилгах</p> <p>Ажиглалтын төлөвлөгөө :</p> <ul style="list-style-type: none"> • Шээсний гарц ,тоо хэмжээ,өнгө ,үнэрийг ажиглах <p>Хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө :</p> <ul style="list-style-type: none"> • Шингэн зүйлийг тохируулан хэрэглэх • Оройн цагаар амаар уух шингэнийг багасгах • Хажуу талаар нь унтуулах <p>Дулаан хувцаслах</p> <ul style="list-style-type: none"> • Ууц нуруу, давсаг орчмоор бүлээн жин тавих <p>Эрүүл мэндийн боловсрол олголт</p> <ul style="list-style-type: none"> • Хүнд юм өргөхгүй байх • Шаардлагатай бол /ариун цэврийн хэрэглэл, хэрэглэх/ • Хувийн ариун цэврийг сахих • Хэвлийн дотоод даралт ихсэх үед гэдэсний булчин ,үтрээ,шулуун гэдэсний төгсгөлхэсгийг чангалах хэвшлийг бий болгох /хүчтэй ханилагах,найтаах г.м/ • Доод мөч, аарцгийн булчин чангалах дасгал зааж өгөх • Сэтгэл санааг тайван байлгах 	<ul style="list-style-type: none"> • Шээсний гарц,тоо,өнгө үнэрийг ажиглан тэмдэглэл хөтлөх • Өдрийн цагаар шингэн зүйлийг тохируулан уулгах • Унтахаас 2-3 цагийн өмнө шингэнийг хязгаарлах • Ууц нуруу, давсаг орчмоор бүлээн жин тавих • Давсганд ачаалал өгөхгүйгээр хажуу тийш харж унтах • Даарч хөрөхөөс сэргийлж дулаан хувцаслуулах • Хүнд юм өргөхөөс аль болох зайлсхийх • Шээс ихээр алдаж буй үед памперс хэрэглэх • Хувийн ариун цэврийг сахиулж угаалга цэвэрлэгээ ,асаргаа сувилгааг тогтмол хийж тэмдэглэл хөтлөх • Аарцгийн булчин чангалах кегелийн дасгалыг зааж өгч

		<p>өдөрт 2-3 удаа хийлгэж хэвшүүлэх</p> <ul style="list-style-type: none"> • Сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх / #44 оношийг авч хэрэгжүүлж болно. /
<p>#26 Шээс хаагдсан #27 шээс ялгаруулалт саатсан</p> <p>1. Бөөрний үйл ажиллагааны алдагдал</p> <p>2. Шээсний сувгийн нарийсал болон дарагдал</p>	<p>Зорилго: Шээс хаагдсан болон ялгаруулалт саатсан зовуурийг арилгах</p> <p>Ажиглалтын төлөвлөгөө :</p> <ul style="list-style-type: none"> • Ажиглалт хийж амин үзүүлэлтүүдийг хэмжиж тэмдэглэх • Шээсний гарц тоо, хэмжээ, өнгө, үнэр, өвдөлтийн хүч ,байрлал, давтамжийг үнэлэх ажиглах • Хавагналтыг ажиглах • Давсагт шээстэй эсэхийг үнэлэх / бодит үзлэг хийх, үйлчлүүлэгчээс асуумж авах / <p>Хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө :</p> <ul style="list-style-type: none"> • Хөдөлгөөнийг хязгаарлаж хэвтрийн дэглэм сахиулах • Хоногийн шингэний баланс тооцох • Биеийн жин, бүсэлхийн тойрог, шилбэний тойрог хэмжих • Хөл гарт бүлээн жин тавих, иллэг массаж хийх, хөлийг биеийн хэмд байлгах • Шээсний гарц хэмжээ, давтамжийг үнэлэх • Шаардлагатай тохиолдолд давсганд шээлгүүр тавьж шээсийг хэмжих • Шээлгүүр тавьсан болон солих тохиолдолд шээсний ариуншинжилгээг өгөх 	<ul style="list-style-type: none"> • Амин үзүүлэлтийг цаг тутамд үзэв • Хоногийн шингэний балансыг тооцов. • Биеийн жин ... байв. Бүсэлхийн тойрог ..., шилбэний тойрог ... байв. • хэвтрийн дэглэм сахиулав • цаг тутамд Ууц нуруунд иллэг хийж, хөл болон гаранд чийгтэй арчилт хийж өгөв. Хөлийг биеийн хэмд өндөрлөж өгөв. • Хоногт удаа шээсэн. мл байв. Өнгө байв. Тунадастай/тунадасгүй байгааг үнэлэв. • Эмчийн заалтаар тохирсон шээлгүүрийг халдвар хамгааллын дэглэм баримтлан тавьж тандалтын хуудсыг хөтлөв. • Шээлгүүрийг тавих болон солих тохиолдолд шээсний ариун чанарын шинжилгээг өгөв. • Шээсний гарц тоо, хэмжээ, өнгө

	<ul style="list-style-type: none"> • Халдвархамгаалалындэглэмбаримтлах <p>Эрүүл мэндийн боловсрол олгох төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> • Халдвар хамгааллын талаар өөрт болон ар гэрийнхэнд зөвлөгөө өгөх • Хувийн ариун цэвэр сахиу талаар зөвлөгөөг өгөх • Өөрөө шээх орчин нөхцлийг бүрдүүлэх / крантны ус гоожуулах, хөтөвчинд бие засах орчин нөхцлийг бүрдүүлэх, хаалт тавих, ганцааранг үлдээх / 	<p>үнэр,өвдөлтийг хүч,байрлал,давтамжийг ажиглан тэмдэглэх</p> <ul style="list-style-type: none"> • #29 оношийг баримтлана. • Өөрт болон ар гэрийнхэнд шээлгүүртэй харилцах талаар зөвлөгөөг өгөв / гарын ариун цэвэр / • Хувийн ариун цэвэр сахиулах талаар зөвлөгөө өгөв. • Өөрөө шээх орчин нөхцлийг бүрдүүлэн шээлгэв.
<p>#28 Цус алдах эрсдэл</p>	<p>Зорилго: Цус алдалтын эрсдэл хүндрэлээс сэргийлэх</p> <p>Ажиглах төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Ажиглалт хийж амин үзүүлэлтүүдийг хэмжиж тэмдэглэх - Бодит үзлэг хийх/ арьс салст, захын судасны хүчдэл дүүрэлтийг тодорхойлох, / - Цусны ерөнхий шинжилгээг хянах - Цус алдах эрсдлийг тодорхойлох/ гэмтэл, эмэгтэйчүүд, дотор, чих хамар хоолой, хавдар, мэс засал, цусны эмгэг / - Шокын эрсдлийг тодорхойлох <p>Хэрэгжүүлэх төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Хөдөлгөөнийг хязгаарлах - Байрлалыг зөв байрлуулах - Цус тогтоох аргуудыг хэрэглэх / даралттай боолт хийх, чиг тавих, чихээс хийх, бөөрөнхий мөс залгиулах, хүйтэн жин 	<ul style="list-style-type: none"> - Амин үзүүлэлтийг цаг тутамд хянахад байв - Ухаан санааны байдлыг үнэлэв. - Арьс салстыг үзэхэд байв. Захын судасны хүчдэл дүүрэлтийг тодорхойлоход 2 секундээс их/бага байв. - Цусны шинжилгээг өдөр тутамдаа хянадаг байх - Цус алдах эрсдлийг тодорхойлоход эрхтний цус алдалт байна. - Шээс, Бөөлжилтийг ажиглахад хэмжээтэй өнгөтэй, гарсан. - Баасны өнгийг ажиглахад хэмжээтэй

	<p>тавих, эмчийн заалтаар цус тогтоох эмчилгээ хийх/</p> <ul style="list-style-type: none"> - Цус алдаж байгаа үед цусны хэмжээ, өнгө, давтамжийг ажиглаж тэмдэглэх - Халууныг үзэх, цусны шинжилгээний талаар эмчид мэдээлнэ - Шингэний балансыг тооцох - Хөл, гарт бүлээн жин тавих - Тасралтгүй хяналтанд байлгах <p>Эрүүл мэндийн боловсрол олгох төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Сэтгэл зүйн зөвлөгөөг өгөх - Хоололтын зөвлөгөөг өгөх - Өөрт болон ар гэрийнхэнд цус алдах эрсдэл үүсэх үеийн зөвлөгөө өгөх - Халдвар хамгааллын дэглэмийн талаар зөвлөгөө өгөх 	<p>судалтай/ судалгүй гарсан.</p> <ul style="list-style-type: none"> - Хоногийн шингэний балансыг хянах - Хөл/ гарт бүлээн жинг 20-30 минут тавьж, сольж өгөв. - Бөөлжилт болгоны дараа амыг цэвэр усаар зайлуулж, гарсан зүйлийг халдваргүйжүүлнэ. - Цус алдалтаас айж сандрахгүй тайван байхыг зөвлөв. - Хагас шингэн бүлээн хоол бага багаар идэхийг зөвлөв. Амаар бүлээн шингэн зүйл бага багаар уухыг зөвлөв. - Цус алдалтын байршил, алдалтын хэмжээ, зэргээс хамааран бүлээн, хүйтэн зүйл уулгахыг зөвлөнө.
<p>#29 Халдварын эрсдэл</p>	<p>Зорилго: Халдварын эрсдлийг бууруулах урьдчилан сэргийлэх</p> <p>Ажиглах төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Амин үзүүлэлтийг үзэх - Зориудын болон зориудын бус шархны байрлал, байдлыг ажиглах - Биеийн аль хэсэгт халдварын эрсдэл байгааг ажиглах / Интубацийн гуурс, судасны гуурс, шээсний катетр, ТВГ, дабль гуурс, плеврийн гуурс, хэвлийн гуурсны, шархны 	<ul style="list-style-type: none"> - Амин үзүүлэлтийг цаг тутамд үзэв. - Шархны байршил байдал гуурсаар мл шингэн өнгөтэй байна. - Шарх цэвэр, бохир удаа боолт хийгдэнэ. Тандалтыг тухай бүрд бичив. - гуурсанд цагт боолтыг сольж цагт угааж халдваргүйжүүлэх

	<p>вакум гуурс байрлал, байдал, гуурсаар гарч байгаа шингэнийг ажиглах</p> <p>Хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Интубацийн гуурс, судасны гуурс, шээсний катетр, ТВГ, дабль гуурс, плеврийн гуурс, хэвлийн гуурс, шархны вакум гуурс, урсгуур гуурсны байрлал, байдал, гуурсаар зориудын болон зориудын бус шархыг цэгцлэх, угаах, цэвэрлэх, ариун боолт хийх - Катетр болон гуурснуудыг хүлээлцэх, / улайсан, шархалсан, хатуурсан хөндийрсөн зэргийг/ - Халдвар хамгааллын дэглэмийг чанд баримтлах - Шарх, катетр болон гуурсны тандалтыг бичих - Халдварын эрсдлийн шинж тэмдэг илэрсэн тохиолдолд эмчлэгч эмчид болон халдвар судлаач эмчид мэдээллэх - Шаардлагатай тохиолдолд бактериологи шинжилгээг авах <p>Эрүүл мэндийн боловсрол олгох</p> <ul style="list-style-type: none"> - Гарын эрүүл ахуйг зөвлөх - Шарх болон гуурстай харилцах талаар зөвлөгөөг өгөх - Боолт бохирдсон тохиолдол бүрт сувилагчдаа мэдээллэх - 	<p>бодисоор цэвэрлэж өгөв.</p> <ul style="list-style-type: none"> - Биеийн хэсэгт байрласан гуурсыг цагт хүлээн авахад боолт цэвэр/бохир, хатуурсан, улайсан байна. - Зориудын бус шархыг үнэлэх цэвэр боолт хийх уусмалаар халдваргүйжүүлж, тос тавьж боолт хийв. - Гараа зөв угаах, бие засах болон бохирдсон тохиолдол бүрт гарыг угаах зааврыг өгөх. - Халдварын эрсдлийн шинж тэмдэг илэрсэн тохиолдолд эмчлэгч эмч болон халдвар судлаачид мэдээлэн бактериологи шинжилгээг өгөв. - Шарх гуурсаа оролдохгүй байх маажихгүй байх талаар зөвлөгөө өгөв - Боолтыг бохирдсон, нэвтэрсэн тохиолдол бүрт сувилагчид мэдээллэх, боолтоо солиулахыг зөвлөв.
<p>#30</p> <p>Арьсны бүрэн бүтэн байдлын алдагдал</p>	<p>Зорилго:</p> <p>Эмчлүүлэгчийн арьсны бүрэн бүтэн байдлыг алдагдсан үед нэмэлт зовуурийг багасгах</p> <p>Ажиглах төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Арьсны бүрэн бүтэн байдлыг ажиглах / улайлт, нуралт, 	<ul style="list-style-type: none"> - Арьсны өнгө, загтнаа тууралт, хавдаж, улайсан, холголт, цооролт өгсөн эсэхийг үнэлэв. / байршил, хэмжээг тодорхой бичих/

	<p>цэврүү, холголт, цооролт, тууралт, загтанаа, харшил, зориудын болон зориудын бус шарх , тариа хийсэн газар улайх, хавдах, шинж тэмдэг илэрсэн эсэхийг байнга шалгах</p> <ul style="list-style-type: none"> - Арьсны бүрэн байдал алдагдсан үед байрлал, хэмжээ, өнгө, шархны гүн, үнэр зэргийг ажиглана. <p>Хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Байрлалыг тогтмол сэлгэх - Арьс салстын бүрэн бүтэн байдлыг өдөр бүр шалгах - Тухайн шархны онцлогт тохирсон боолтыг хийх / тосон, сеткин, цацлага, хуурайшуулах , гэх мэт / - Халдвар хамгааллын дэглэм баримтлах - Бүтэн биеийн болон хэсэгчилсэн угаалга хийх - Хэрэв тариа судаснаас гадуур гарсан тохиолдолд хориг тавих, хүйтэн жин тавих гарыг өндөрлөх - Өөрчлөлт гарсан хэсэгт 10% натрийн уусмалаар жин тавих, цэвэр боолт хийх <p>Эрүүл мэндийн боловсрол олгох төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Сахиурт асаргаа сувилгааны зөвлөгөөг өгөх - Хоололтын зөвлөгөө өгөх - Хувцаслалтын зөвлөгөө өгөх - Цагаан хэрэглэлийг цэвэр цэгцтэй засах - Судас дагаж харлах өвдөх, хагарах, улайх мэдээлэл олгоно 	<ul style="list-style-type: none"> - Байрлалыг тутамд сольв - Биеийн хэсэгт уусмалаар, усаар цагт хэсэгчилсэн/ бүтэн биеийн угаалга хийв. - Байрлалыг цаг тутамд сэлгэв. - Тухайн шархны онцлогт тохирсон боолтыг хийж өгөв. - гарын хөлийн судасны гадуур тариа хийсэн, жин, натрихлоридын уусмалаар жин тавьж боолт хийв. - Сахиурт болон ар гэрийнхэнд асаргаа сувилгааг хийх талаар зөвлөгөө өгөв. <p>/ холголт цооролттой үйлчлүүлэгчид цагаан хэрэглэлийг цэвэр хуурай, хуниас нугачаасгүй байлгах, холголт цооролт үүссэн хэсгийн шархыг удаан дарагдахаас сэргийлж байрлалыг тогтмол сэлгэх, Байрлал сэлгэх явцдаа үйлчлүүлэгчид нэмэлт зовиур үүсгэхээс сэргийлэх / зулгалах, чирэх, / Цооролт үүссэн хэсэгт иллэг массаж хийхгүй байх</p> <ul style="list-style-type: none"> - Амин дэм, эслэгээр баялаг, тэжээллэг
--	---	--

		<p>хоолыг ойр ойрхон бага багаар өгөв.</p> <ul style="list-style-type: none"> - Хувцас нь том оёдолгүй, резин сул, том товчгүй байх, дотуур өмд нь өмсөж тайлахад хялбар байх - Судас дагаж хорсож, өвдөх, хагарах, улайвал сувилагчид мэдээлэх хориг арга хэмжээг авав.
#33Халуурах	<p>Зорилго: Эмчлүүлэгчийн халууныг бууруулах</p> <p>Ажиглах төлөвлөгөө :</p> <ul style="list-style-type: none"> - Биеийн халуун үзэх - Цусны шинжилгээг ажиглах - Амин үзүүлэлтийг тогтмол үзэж амин үзүүлэлтийн хуудсанд тэмдэглэх <p>Хэрэгжүүлэх төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Биеийн дулаан 38 хэмээс доош бол механик аргаар халуун бууруулах - Хүйтэн бигнүүр тавьж дулаан хучиж хэвтүүлэх/хүйтэн жин бигнүүрийг суга ,цавь,шилэн хүзүүнд тавих/ - Нимгэн арьстай хэсэгт арчилт хийх - Цагаан хэрэглэл дэлгэш даавууг норсон тохиолдол бүрт солих - Дулаан хучиж хэвтүүлэх - Амаар хангалттай шингэн уулгах - Шингэний балансыг тооцох - Чийгтэй алчуураар бүх биеийг арчих - Холголт цооролт үүсэхээс сэргийлэх 	<ul style="list-style-type: none"> - Биеийн халууныг үзэхэд..... байв. Амин үзүүлэлтийн хуудсанд тэмдэглэв. - Хүйтэн жин бигнүүрийг биеийн хэсэгт минут тавив - Биеийн нимгэн арьстай хэсэгт удаа арчилт хийв. - Цагаан хэрэглэл болон хувцасыг норсон тохиолдол бүрт сольж өгөв. - Амаар бүлээн шингэн зүйлийг хангалттай уухыг зөвлөв. / хярам, бор цай,буцалсан ус / - Халууралтын үед шингэний балансыг тооцоход байв. / биеийн хэм +1 хэмээр нэмэгдэхэд -500 -г хасаж тооцно./ - Бүх биеийн болон хэсэгчилсэн угаалга хийв.

	<ul style="list-style-type: none"> - Байрлалыг сэлгэх / ивүүр болон дэрийг ивэж өгөх/ - 38 хэмээс дээш халуурч байгаа үед цусны ариун чанар авах <p>Эрүүл мэндийн боловсрол олгох төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Сахиурт амаар хангалттай шингэн уулгахыг зөвлөх - Норсон тохиолдол бүрт хувцасыг солих - Хувийн ариун цэвэр сахих талаар зөвлөгөөг өгөх - Халуурсан тохиолдолд сувилагчид мэдээлэх шаардлагатайг ойлгуулах 	<ul style="list-style-type: none"> - 38 хэмээс дээш халуурч байгаа үед цусны ариун чанар авав. - Уруул амыг чийглэж, амны хөндийг цэвэрлэж өгөв.
<p># 34 Халуун буурах</p>	<p>Зорилго: Биеийн халууныг нэмэгдүүлэх</p> <p>Ажиглах төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Амин үзүүлэлтийг тогтмол хянах - Биед хөрөлт байгаа эсэхийг тодорхойлох <p>Хэрэгжүүлэх төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Бүлээн жин бигнүүрийг биеийн хэсгүүдэд тавих - Уух чадвартай бол амаар халуун бүлээн шингэнийг ихээр уух - Дулаан хучиж хэвтүүлэх - Сахар тодорхойлох <p>Эрүүл мэндийн боловсрол олгох төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Асаргаа сувилгааны талаар зөвлөгөө өгөх - Бүх бие болон хэсэгчилсэн бүлээн усаар угаах, тослож өгөх / захын эрхтний цусан хангамжийг сайжруулах/ 	<ul style="list-style-type: none"> - Амин үзүүлэлтийг үзэхэд байв. Амин үзүүлэлтийн хуудсанд бичиж тэмдэглэв. - Бүлээн жин бигнүүрийг биеийн хэсэгт минут тавив. - Амаар шингэн зүйл хангалттай уухыг / хярам, буцалсан хросол зэргийг бага багаар уулгах/ - Дулаан хучиж өгөв. - Хоногт удаа хэмийн усаар бүтэн болон хэсэгчилсэн угаалгыг хийж, тослож өгөв. - Захын судсанд сахар тодорхойлоход байв.

<p>#37 Ярих чадвар саатсан</p>	<p>Зорилго: Эмчлүүлэгчийн өдөр тутмын үйл ажилгааг хэвийн байлгах</p> <p>Ажиглах төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Анхаарал төвлөрөлт, ой тогтоолтыг ажиглах - Мэдээллийг хүлээн авах чадварыг үнэлэх - Нүүр хувиралтыг ажиглах / хариу үйлдлийг ажиглах/ - Өөрийгөө илэрхийлэх чадварыг үнэлэх - Хэл ярианы байдлыг ажиглах <p>Хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Ярилцах болон өөртөө үйлчлэх үед тусална. - Үйлчлүүлэгчийг толинд харуулж авиа дуудлагын дасгал хийлгэх - Өөрт ойр хэрэглэгддэг үг хэллэгийг түлхүү хэлүүлэх / үйл үг, нэр үг гэсэн дарааллаар хэлүүлэх/ - Харилцах хэрэгсэл бал, цаас, зурагт үзүүлэн зэргийг бэлтгэж өгнө. - Аминүзүүлэлийг хянана. <p>Эрүүл мэндийн боловсрол олгох төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Харилцах чадвар эрс муудсан үед эмчид мэдээлнэ. - Хяналтыг тасралтгүй үргэлжилүүлнэ 	<ul style="list-style-type: none"> - Анхаарал төвлөрөлт, ой тогтоолтыг..... байв - Мэдээллийг хүлээн авах чадварыг үнэлэхэд байв. - Нүүр хувиралтыг ажиглав / хариу үйлдлийг ажиглах/ - Өөрийгөө илэрхийлэх чадварыг үнэлэхэд байв. - Хэл ярианы байдлыг үнэлэхэд байв. - Үйлчлүүлэгчийг толинд харуулж авиа дуудлагын дасгал хийлгэв - Өөрт ойр хэрэглэгддэг үг хэллэгийг түлхүү хэлүүлж ярилцлага хийв / үйл үг, нэр үг гэсэн дарааллаар хэлүүлэх/ - Харилцах хэрэгсэл бал, цаас, зурагт үзүүлэн зэргийг бэлтгэж өгнө. - Харилцах чадварыг тогтмол үнэлж мэдээлэв.
<p>#39 Өвдөлт</p>	<p>Зорилго: Үйлчлүүлэгчийг зовуурийг багасгах</p> <p>Ажиглах төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Өвдөлтийн баллаар үнэлэх - Амин үзүүлэлтийг хянах <p>Хэрэгжүүлэх төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Хүйтэн жин тавина - Байрлалыг сонгох <p>Өвдөлтийн хүндрэлээс сэргийлэх</p>	<ul style="list-style-type: none"> - Өвдөлтийн цагт нүүрний илрэлээр үнэлэхэд балл байв. - Амин үзүүлэлтийг хянахад байв. - Хүйтэн жин минут тавьж, минут завсарлав. СМ-3

	<p>Эмчийн заалтаар өвдөлт намдаах эмчилгээ хийх Өвдөлт намдаах эмчилгээний дараах үр дүнг тооцох Өвдөлтийн зэргээс хамаарч байнгын хяналтанд байлгах Өвдөлт хянах хуудас хөтлөх Эрүүл мэндийн боловсрол олгох төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх - Хувцаслалтын зөвлөгөө өгөх - Хоололтын зөвлөгөө өгөх 	<p>хавсралт -13 /Өвдөлт хянах хуудас/ хөтлөв. цагт өвдөлт намдаах эмчилгээг хийхэд дараа өвдөлт намдсан/ намдаагүй бол эмчилгээг давтан авав. Өвдөлт намдсан. Сэтгэл санааг дэмжих эдгэрнэ, өвдөлтгүй болно гэсэн итгэл төрүүлэх Биед эвтэйхэн, зөөлөн хувцас өмсөхийг зөвлөв. Хоололтой холбоотой өвдөлттэй бол хоолыг сойх, Тухайн өвчний үеийн эмчилгээний хоолыг зөвлөв.</p>
#41 Айдас	<p>Зорилго: Гадна болон дотоод шалтгааны айдсыг тодорхойлж эрсдлээс сэргийлэх Ажиглах төлөвлөгөө: Сэтгэл зүйн байдлыг ажиглана. Хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө: Үйлчлүүлэгчтэй ярилцаж, айдас байгаа эсэхийг тодорхойлох Айдасын шалтгааныг тодорхойлох Зааврын дагуу эмчилгээ үйлчилгээг хийнэ. Эмийн үр дүнг заавал мэдээлнэ. Сэтгэл зүйг дэмжиж тайвшруулах Эрүүл мэндийн боловсрол олгох төлөвлөгөө: Эмчилгээ үйлчилгээний талаар тайлбарлаж ойлгуулах Өөрт туслах тохиолдолд сувилагчид мэдээллэхийг зөвлөх Хяналтын тасралтгүй хийнэ</p>	<p>Үйлчлүүлэгчийн ажиглалтыг сайжруулан, эрсдлийг тооцоолон сэргийлэх Ярилцах орчинг бүрдүүлэх Эмнэлгийн тусламж үйлчилгээний талаар зөв ойлгуулан ярилцаж зөвлөгөө зөвлөмжийг өгөн ойлгуулах.</p>
#44 Ганцаардах эрсдэл	<p>Зорилго: Үйлчлүүлэгчийг ганцаардах эрсдлээс сэргийлэх Ажиглалтын төлөвлөгөө:</p>	<p>Үйлчлүүлэгч ганцаардаж шаналсан шинж буй эсэхийг ажиглаж тэмдэглэл хөтлөх</p>

	<p>Үйлчлүүлэгчид илэрч бус шинж тэмдгээс нь шалтгаалан айх ганцаардах сэтгэл санаа тавгүйрхэх шинж байгаа эсэхийг ажиглах Хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө: Зураг зуруулах г.м /ахуй заслыг дэс дараалалтай хийлгэх/ Өдөрт 2-с доошгүй удаа гадаа салхилуулах Сувилагч үйлчлүүлэгчийн хувьд хамгийн ойрын туслагч байх Үйлчлүүлэгчид үнэн зөв мэдээлэл өгөх Үйлчлүүлэгчид ээлтэй, орчинг бүрдүүлэх Үйлчлүүлэгчийн эдгэрэлтэнд сайнаар нөлөөлөхүйц сэтгэл зүйн үйлчилгээг тогтмол үзүүлэх Эмчилгээ сувилгааны үр дүнгийн талаар мэдээллийг байнга өгөх Үйлдлийг хийхдээ гарч болзошгүй хүндрэлээс сэргийлж ажиллах Үйлчлүүлэгчийн ар гэрийнхэнтэй холбоотой ажиллах Жижиг бүлгийн сургалт зохион байгуулах Өрхийн эмнэлэг болон хорооны НЭМ-н ажилтантай холбож өгөх Эрүүл мэндийн боловсрол олгох төлөвлөгөө: Сэтгэл санааг тайван байлгах Гэр бүлийнхэнтэйгээ харилцаатай байх боломж олгох Эмчлэгч эмчтэйгээ санал бодлоо солилцох нөхцлийг бүрдүүлэх</p>	<p>Үйлчлүүлэгчийнчадварыгүнэ лэх Сувилагч үйлчлүүлэгчийн хувьд хамгийн ойрын үнэнч туслагч сэтгэлийг ойлгон дэмчигч, урам дэм өгөгч, дотны зөвлөгч байх Үйлчлүүлэгчийн үг яриаг хүлээцтэй сонсоод харилцан ярилцаж эдгэнэ гэсэн итгэлийг төрүүлж урам зориг өгөх Үйлчлүүлэгчид ээлтэй, нээлттэй орчин, эелдэг харилцааг бий болгох Эмчилгээ сувилгаанд гарсан эерэг үзүүлэлтүүдийг байнга танилцуулах Ганцаардсан үйлчлүүлэгчтэй харилцахдаа алдаа гаргахаас сэргийлэх Үйлчлүүлэгчийн ар гэрийнхэнд нь сэтгэл санааг дэмжих ганцаардуулахгүй байлгах талаар зөвөлгөө өгөх Ганцаарчилсан сургалт хийх Эмчтэйгээ ярилцаж эрүүл мэндийн байдлын талаарх мэдээлэл авах боломжоор хангах</p>
<p># 51 Хавагнах</p>	<p>Зорилго: Үйлчлүүлэгчийг хавагналыг үнэлэх, хавагналт үүсэхээс сэргийлэх Ажиглах төлөвлөгөө: Биеийн аль хэсэгт хавагнасныг үзэх</p>	<p>Жинг үзэхэд байв. Хоногийн шингэний балансыг тодорхойлоход +/- байв. Эмчид мэдээлэв.</p>

	<p>Хаван хатуу зөөлөн эсэхийг тодорхойлох Хаван шилжиж байгаа эсэхийг үнэлэх Шээсний гарцыг үнэлэх Хэрэгжүүлэх төлөвлөгөө: Биеийн жинг тодорхойлох Хэвлийн тойрог үзэх Хоногийн шингэний балансыг тодорхойлох Эрдэсийн дутагдалд орохоос сэргийлэх Хавагналтын байдлаас шалтгаалж цээж хөлийг биеийн түвшнээс дээш өндөрлөх Их хавагналтын үед арьс язарч, ус шүүрч бохирдож, халдварлах учраас арьсыг тогтмол угааж байрлалыг сэлгэж, дэлгэш даавууг солих, Эрүүл мэндий боловсрол олгох төлөвлөгөө: Эрдэс бодисын дутагдалд орохоос сэргийлэх Зүрхний дутагдлын болон цусны их эргэлтийн хавангийн үед уух зүйлийг хязгаарлах Хувцаслалтын зөвлөгөөг өгөх Давсны хэргэлээг хязгаарлах Амин дэм, уургаар баялаг хоолыг өдөрт 3-4 удаа бага багаар хооллохыг зөвлөх -</p>	<p>Кали, натрийн тогтолцоог хянах, шинжилгээг харахад кали, натри ... байв. Аль болох давсын хэрэглээг хязгаарлах, цайг давсгүй ууж хэвших, хоолыг бага зэргийн давстай хөнгөн хоол идхийг зөвлөх. Өтгөн сүүтэй цай, кофе, хийжүүлсэн ундаа, уухыг хориглох Байрлалыг цаг, минут тутамд сэлгэж, дэлгэш даавууг ...удаа сольж өгөв. Биеийн ... хэсгийн арьс язарч хаван шүүрсэн. Бие бариагүй хөвөн даавуун материалаар хийгдсэн байх</p>
--	---	---

<p># 52 Сул саа, Хөшүүн саа / тал доод мөчний, 4 мөчний/ саа үүссэн.</p>	<p>Зорилго: Саа саажилтын үлдэцийг багасгах</p> <p>Ажиглах төлөвлөгөө: Биеийн аль хэсэгт саа саажилттайг ажиглах Мөчдийн далайцыг тодорхойлох Байрлал болон хөдөлгөөний идэвхид нөлөөлж буйг ажиглах</p> <p>Хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө: Байрлалыг 2 цаг тутамд сэлгэх Саажсан гар хөлзөвбайрлалд ивээс, тохойвчөсгийвч , томжигдэрхэрэглэх Амны хөндий эрүүл ахуйг сахиулах Саажсан талын гар хөлийг зөв сойлго хийнэ. / хэвтэрт суугаа байрлалд / Мөч тэнийлгэх дасгал хөдөлгөөн хийлгэнэ Босох, суух, хооллох үед саажилттай талаас нь тулах дасгалыг хийж харилцана. Массаж хийх, өөрт тохирсон хөдөлгөөн дасгал хийлгэнэ. Сэргээн засах эмчээс зөвлөгөө авах. Залгих рефлексийг тодорхойлох Унаж бэртэхээс сэргийлэх</p> <p>Эрүүл мэндийн боловсрол олгох төлөвлөгөө: Ар гэрийнхэнд асаргаа сувилгааны зөвлөгөөг өгөх Өөрт тохирсон дасгал хөдөлгөөн хийхийг зөвлөх Хувцаслалтын талаар зөвлөгөөг өгөх Хоололтын зөвлөгөөг өгөх</p>	<p>Байрлалыг цаг тутамд сэлгэв. Биеийг цагт тослож, иллэг массаж хийж өгөв. Саажсан гар хөл зөв байрлалд ивээс, тохойвч өсгийвч , том жижиг дэр хэрэглэв. Гар хөлийг тэнийлгэх, өөрт тохирсон дасгалыг өдөрт удаа хийлгэв. Амны хөндийг % уусмалаар угаав. цагт грамм хоолыг амаар өгөв. Ар гэрийнхэнд харвалттай үйлчлүүлэгчидтэй харилцахБосох, суух, хооллох явах үед саажилттай талаас нь тулах, унаж бэртэхээс сэргийлэхийг зөвлөв. Сэргээн засах эмчийн зөвлөгөөний дагуу хөдөлгөөн заслыг хийхийг зөвлөв. Сахиурыг байнгын асаргаа сувилгаанд сургах, хөдөлгөөн засалд сургах Хөвөн даавуун материалаар хийгдсэн өмсөж тайлахад хялбар урд энгэр задгай байх, саатай саажилттай талаас эхлэн өмсгөх Илчлэг, уураглаг, амин дэмээр баялаг хоол хүнснийг түлхүү хэрэглэхийг зөвлөх</p>
<p>#53 Таталттай уналттай</p>	<p>Зорилго: Уналт таталтын үед бэртэж гэмтэх, амьсгалын зам бөглөрөх эрсдлээс сэргийлэх</p> <p>Ажиглах төлөвлөгөө: Асуумжийг авах</p>	<p>Уналт таталттай эмчлүүлэгчийн орчинд үнэлгээ өгөн, хурц ирмэгтэй зүйлийг холдуулан Аль болох байнгын сахиуртай байлгах</p>

	<p>Бодит үзлэг хийх / биеийн хэсэгт гарсан механик өөрчлөлт /</p> <p>Хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө:</p> <p>Өрөөнд агаарын сэлгэлт хийх Үйлчлүүлэгчийн орчны аюулгүй байдлыг бүрдүүлэх Уналт болон таталтын үед авах арга хэмжээний мэдлэгийг дээшлүүлэх Таталт уналтын эмийг хяналттай уулгах</p> <p>Унасан тохиолдолд:</p> <p>Аюулаас холдуулах / сувилагч өөрийгөө эрсдлээс сэргийлэх / Үйлчлүүлэгчийн толгой гэмтэхээс сэргийлэх Амьсгалын замыг чөлөөлнө. Зөв байрлуулах Хэл хазагдахаас сэргийлэх Таталтын хугацааг хянах Таталтын эсрэг эмчилгээг эмчийн заалтаар хийх</p> <p>Эрүүл мэндийн боловсрол олгох төлөвлөгөө:</p> <p>Ар гэрийнхэнд уналт таталтын үед үзүүлэх тусламж үйлчилгээний талаарх зөвлөгөө Хувцаслалтын талаар зөвлөгөөг өгөх Хагас шингэн хоолыг өгөх</p>	<p>Өрөөнд агаарын сэлгэлтийг тогтмол хийв . / хэт халуун бүгчим, агааржилт муутай өрөөнд байлгахгүй байх/ Үйлчлүүлэгчийн орчны аюулгүй байдлыг бүрдүүлэх / үзүүртэй, ирмэгтэй зүйл, шил шаазанг холдуулах, халуун хоол цайнд түлэгдэхээс сэргийлэх Уналт таталт үүссэн үед тухайн үйлчлүүлэгчийн мэдрэг эм тариаг бэлэн байлгах Бие бариагүй өмсөж тайлахад хялбар, энгэрт товчтой цамц өмсгөх, Хахах болон хэл хазагдахаас сэргийлэх Үйлчлүүлэгчид хагас шингэн хоол идэхийг зөвлөв.</p> <p>Уналтын өмнө:</p> <p>Таталт уналтын эмийг эмчийн заалтын дагуу гардан уулгав.</p> <p>Уналтын үед:</p> <p>Ар гэрийнхэнд болон сахиурт уналт таталтын үед айж сандрахгүй байх, унасан үед амаар уух зүйл болон эмийг өгөхгүй байхыг анхааруулах, чангарсан булчинг хүчээр суллахгүй байхыг зөвлөв.</p> <p>Уналтын дараа:</p> <p>Байнгын сахиуртай байлгахыг зөвлөв. Уналтын эмийг дур мэдэн солиулахгүй байх, хорт зуршлын хэрэглээг хориглох Байнгын асаргаа сувилгаанд сахиурыг сургаж дадлагажуулна.</p>
--	---	---

<p>#54 Тэнцвэрийн алдагдал</p>	<p>Зорилго: Тэнцвэр алдагдлыг тогтоох, гарах хүндрэлээс урьдчилан сэргийлэх</p> <p>Ажиглах төлөвлөгөө: Тэнцвэр алдагдлыг тодорхойлох Амин үзүүлэлтийг тогтмол хянах Үйлчлүүлэгчийг зөв үнэлэх</p> <p>Хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө: Үйлчүүлэгчийн орчны аюулгүй байдлыг сайжруулах Хэвтрийн дэглэм сахиулах Захын судсандахь сахар хянах Хооллох, бие засахад туслах дэмнэх Бөөлжилт болон дотор муухайрах эрсдэл үүсэхээс сэргийлэн бэлэн байдлыг хангах Эмчийн заалтаар эмчийн заалтаар хийх</p> <p>Эрүүл мэндийн боловсрол олгох төлөвлөгөө: Ар гэрийнхэнд асаргаа сувилгааны зөвлөгөөг өгөх Үйлчлүүлэгчид хэвтрийн дэглэм баримтлахыг зөвлөх</p>	<p>Амин үзүүлэлтийг тогтмол үзэж амин үзүүлэлтийн хуудсанд хөтлөв. Хэвтрийн дэглэм сахиулав. Захын судсандахь сахарыг хянахад байв. Бөөлжилт үүсэх, хахахаас сэргийлэн хагас шингэн хоол идэх, шингэн зүйл хангалттай уулгахыг зөвлөв. Байнгын сахиуртай байх, сахиурт асаргаа сувилгааны зөвлөгөөг өгөх / хооллох, бие засахад нь туслах Үйлчлүүлэгчид огцом хөдлөхгүй дасгаж хөдөлгөөн хийхийг зөвлөв.</p>
<p>#55 Зогисолт үүссэн</p>	<p>Зорилго: Зогисолтыг намдаах</p> <p>Ажиглах төлөвлөгөө: Зогисолтын хугацааг, давтамжийг тодорхойлох</p> <p>Хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө: Үйлчүүлэгчийн тайван нөхцөл байдалд байлгах Хоолыг тайван залгиулж идүүлэх Амьсгааг түр түгжүүлэх Бүлээн шингэн зүйл уулгана. Эмчийн заалтаар эмчилгээ хийх</p> <p>Эрүүл мэндийн боловсрол олгох төлөвлөгөө: Хоолыг идэхдээ тайванажилж идэхийг зөвлөх</p>	<p>Үйлчлүүлэгчийн хооллох орчинг өөрт тухтай нөхцлийг бүрдүүлэв. Хагас шингэн бүлээн хоолыг тайван бага багаар идэхийг зөвлөв. Амьсгааг хэсэг хугацаанд түгжиж, зөөлнөөр амьсгалаа гаргахыг зөвлөв. Амаар бүлээн шингэн хангалттай уухыг зөвлөв. / тайван бага багаар уух / Эмчилгээг эмчийн заавраар хийн, үйлчлүүлэгчээ тогтмол хянаж мэдээллэх</p>

	<p>Амаар хангалттай бүлээн шингэн уухыг зөвлөх</p>	
<p>#56 Хэлгүйдэл болон ойгүйдэл / танин мэдэхүй алдагдсан /</p>	<p>Зорилго: Хэлгүйдэл болон ойгүйдлийг сэргээх</p> <p>Ажиглах төлөвлөгөө: Анхаарал төвөлөрөлт, ой тогтоолт Мэдээллийг хүлээн авах байдал Өөрийн санаа бодлоо илэрхийлэх байдал Нүүр хувиралт, дуу авиа гаргалт Өөрийн санаа бодлоо илэрхийлэх байдал зэргийг сувилагч анхааралтай ажиглаж, дүгнэлт хийх</p> <p>Хэрэгжүүлэх төлөвлөгөө: Үйлчлүүлэгчийг толинд харуулж,авиан болон дуудлагын дасгал хийлгэх Хамгийн ойр хэрэглэгдэх үгсийг хэлүүлэх Зураг үзүүлж, үг хэлүүлэх Ойг сайжруулах дасгал харилцан ярилцах Урьд нь хийдэг байсан зүйлийн жагсаалтыг гаргах</p> <p>Эрүүл мэндийн боловсрол олгох төлөвлөгөө: Хооллох, хувцаслах үе шат бүрийг зааварчлах Сахиурт ар гэрийнхнийг асаргаанд сургах, ойлголцоход сургаж дадлагажуулах</p>	<p>Үйлчлүүлэгчээ бүрэн гүйцэт үнэлэх Үйлчлүүлэгчээ тогтмол цагт үг хэлэх, ой сайжруулах дасгал хөдөлгөөнийг хийлгэв. Өдөрт шат дарааллаар дасгал хөдөлгөөний ахицтай хийхийг зөвлөв. Зурагт телевизийг үзүүлэн, гарт зураг зуруулах, дуу хөгжмийг сонсгов.</p>

<p>#57 Тархинд цус харвах</p>	<p>Зорилго: Харвалтын дараах хүндрэлээс сэргийлэх</p> <p>Ажиглах төлөвлөгөө: Ухаан санааны байдлыг үнэлэх Амин үзүүлэлтийг хянах Саа саажилтыг үнэлэх Өвдөлтийг үнэлэх, хянах</p> <p>Хэрэгжүүлэх төлөвлөгөө: Цээжийг өндөрлөх Хүчилтөрөгчийггуурсаарөгөх Амьсгалын замыг чөлөөтэйбайлгах / байрлалыгхажуугаарбайрлуулах, биологийн шингэнд бөглөрөхөөссэргийлэх/ Амны хөндийнариунцэврийгсахиулах Боолт нэвтэрсэн эсэхийг үнэлэх Дотор муухайрах, огиулалт үүсчбайгааэсэхийгажиглах Шээс болон өтгөнийгарцыгхянах Шингэний балансыг хөтлөх Хэвтрийн дэглэм сахиулах Толгойн боолт хийх Хүзүүний гэмтлийн үеийн хүзүүвчийг хийх Байрлалыг болгоомжтой сэлгэх Холголт цооролтоос сэргийлэх Шаардлагатай тохиодолд уян зүү,шээсний катетр, ходоодны зонд тавина.</p> <p>Эрүүл мэндийн боловсрол олгох төлөвлөгөө: Хувцаслалт Хүчтэй хөдлөхгүй байх Бүх биеийг бүлээн устай алчуураар арчиж, тослож өгөх Хоололтын зөвлөгөөг өгөх</p>	<p>- Ухаан санааны байдлыг үнэлэхэд..... байв - Амин үзүүлтийг цаг тутамд хянав. - өвдөлтийг үнэлэхэд балл байв. Цээж өндөрлөв Хүчилтөрөгчийг хамрын хос гуурсаар мл/цагаар минут тутамд өгөв. Амьсгалын замыг чөлөөлж, цэр салстыг цаг тутамд соруулав. Амны хөндийн ариун цэврийг сахиулж, цаг тутамд чийглэж өгөв. Шингэний балансыг тооцов. Боолтыг цаг тутамд солив Байрлалыг цаг тутамд сэлгэж, хэсэгчилсэн болон бүтэн биеийн угаалга хийж өгөв. Ивүүр болон дэр хэрэглэх Хөвөн даавуун материалаар хийгдсэн өмсөж тайлахад хялбар урд энгэр задгай байх, саатай саажилттай талаас эхлэн өмсгөх Шаардлагатай тохиодолд уян зүү, шээсний катетр, ходоодны зонд тавив Өтгөний гарц, хэмжээ, хэлбэрийг ажиглах Сахиурт асаргаа сувилгааны зөвлөгөөг өгөв Шаардлагатай халуун, хүйтэн жинг тавих Илчлэг шим тэжээл бүхий хоолыг хагас шингэн байдлаар бэлтгэн өгөх</p>
-------------------------------	---	--

<p>#58 Мөчдийн гэмтэл</p>	<p>Зорилго: Гэмтлийндараах хүндрэлээс сэргийлэх</p> <p>Ажиглах төлөвлөгөө: Амин үзүүлэлтийг хянах Хялгасан судасны хүчдэл, дүүрэлтийг тодорхойлох</p> <p>Хэрэгжүүлэх төлөвлөгөө: Өвдөлт намдаах эмчилгээг эмчийн заалтаар хийж, СМ-3 хавсралт -13-р хуудсыг хөтлөх Хугарсан мөчдийн хөдөлгөөн хязгаарлах Хугарсан мөчдийг сойлт хийх, шаардлагатай тохиолдолд гипсдэх, Гипс болон боолтондоо холгогдохоос сэргийлэх Хүйтэн жин бигнүүр тавих 15-20 минут тавих Шархтай тохиолдолд #29 оношийг баримтлах</p> <p>Эрүүл мэндийн боловсрол олгох төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Сахиурт болон өөрт зөвлөгөө өгөх - Хугаралтай хэсэгтэй харилцах зөвлөгөөг өгөх - Дээд доод мөчдийн үед гарыг сойх, хөлийг өндөрлөхийг зөвлөх 	<p>Амин үзүүлэлтийг үзэж тэмдэглэв.</p> <p>Захын судасны хүчилтөрөгчийн хангамжийн хүчдэл дүүрэлтийг тодорхойлов.</p> <p>Өвдөлт намдаах эмчилгээг эмчийн заалтаар хийж, СМ-3 хавсралт -13-р хуудсыг хөтлөв</p> <p>Хугарсан мөчдийн хөдөлгөөнийг хязгаарлав.</p> <p>Хугарсан мөчдийг сойлт хийж, шаардлагатай тохиолдолд гипсдэв.</p> <p>Өдөр тутмын хяналтыг сайжруулав.</p> <p>Хүйтэн жинг 15-20 минут тавьж 30 минут завсарлав. Натрийн хлоридын - 10% уусмалаар жин тавив.</p> <p>Сахиурт болон өөрт унаж бэртэхээс сэргийлэх, гипс болон боолттой харилцах зөвлөгөө өгөх</p> <p>Хугаралтай хэсэгийн суларсан болон чанга болсон эсэхийг үнэлэх боолтны сувилагчдаа мэдээллэхийг зөвлөв.</p> <p>Дээд доод мөчдийн үед гар сойх, хөлийг өндөрлөхийг зөвлөв</p>
---------------------------	---	--

<p>#59 Цээж болон хэвлийн гэмтэл</p>	<p>Зорилго: Цээж болон хэвлийн гэмтлийн хүндрэлээс сэргийлэх</p> <p>Ажиглах төлөвлөгөө: Дотуур гэмтэлтэй эсэхийг үнэлэх / #28 цус алдалттай эсэхийг үнэлэх / Амин үзүүлэлтийг үзэх</p> <p>Хэрэгжүүлэх төлөвлөгөө: Цээж өндөрлөнө. Хүчилтөрөгчийг өгөв. Захын судасны цусан хангамжийн хүчдэл дүүрэлтийг тодорхойлох Өвдөлт намдаах эмчилгээг эмчийн заалтаар хийж, СМ-3 хавсралт -13-р хуудсыг хөтлөх Хэвлийн болон цээжний гэмтлийн боолт хийлгэх Гуурсаар гарч шингэний хэмжээг хянах Хэвтрийн дэглэм баримтлах</p> <p>Эрүүл мэндийн боловсрол олгох төлөвлөгөө: Сахиурт асаргаа сувилгааны зөвлөгөөг өгөх</p>	<p>Амин үзүүлэлтийг хянав. Өвдөлтнамдаахэмчилгээгэмчийнзаалтаархийж, СМ-3 хавсралт -13-р хуудсыгхөтлөв. Цээжийг хэмд өндөрлөв. Хүчилтөрөгчийг мл/ц..... цаг өгөв. Хэвлийнболонцээжнийгэмтлийнбоолтхийж, гуурставив. #29 оношийн дагуу Хэвлийн болон цээжний гуурсаар мл..... өнгөтэй шингэн гарав. Хэвтрийн дэглэм чанд баримтлахыг зөвлөв. Сахиурт хэвтрийн дэглэмтэй харилцах талаар зөвлөгөө өгөв. Илчлэг шим тэжээлтэй хагас шингэн хоолыг бага багаар идэхийг зөвлөв. -</p>
--	--	--

<p># 60 Арьс салстын эмгэг өөрчлөлт / цусанд билирубин ихсэлт/</p>	<p>Зорилго: Арьс салстын эмгэг өөрчлөлтийн хүндрэлээс сэргийлэх</p> <p>Ажиглах төлөвлөгөө: Арьс салстын өнгө, эмгэг өөрчлөлтийг ажиглах Биеийн арьс хөлний ул, хэлний уг, гарын алга, тагнай, зэргийг өгөх Нярайд: хөхөлтийн идэвхийг ажиглах Нярайн идэвхийг ажиглах</p> <p>Хэрэгжүүлэх төлөвлөгөө: Арьсны чийглэг байдлыг хангах Бүх биеийн болон хэсэгчилсэн угаалга хийх Бүх биеийг тослож өгөх Эмчийн заалтаар цэс угаах Цэвэрлэх клизм тавих Хоногт уух шингэнийг 2-3 л уулгах Нярайд: фото эмчилгээ хийх Хангалттай хөхийг хөхүүлэх</p> <p>Эрүүл мэндийн боловсрол олгох төлөвлөгөө: Ар гэрийнхэн болон сахиурт асаргаа сувилгааны зөвлөгөө өгөх Хоололтын талаар зөвлөгөө өгөх Хувийн ариун цэвэр сахих Цагаан хэрэглэл тогтмол солих Нярайд: эхэд хөхүүлэх, болон хүүхдийн арьс салстын арчилгааны талаар зөвлөх</p>	<p>Арьс салстын өнгө тууралт маажсан/ тавжсан зүйл байгааг ажиглав.</p> <p>Биеийн арьс хөлний ул, хэлний уг, гарын алга, тагнай зэргийн өөрчлөлт байв. Нярай хүүхдийн хөхөлт болон нярайн идэвхийг үнэлэв. Фото эмчилгээг 24-72 цагийн хугацаанд тасралтгүй хийв. Бүх биеийн угаалгыг хийв. цагт бүх биеийг тослож өгөв. Эмчийн заалтаар цэвэрлэх бургуй тавив. Гар, хөлийн хумсыг дөрвөлжилж авах, хумсны хутганы ирэнд өртөхөөс сэргийлэх, Амны хөндийг угаахдаа зөөлөн үстэй сойзоор угаах, зөөлөн дарж угаахыг зөвлөв. Хамрыг цэвэрлэхдээ анхаарах / хамрыг чийгшүүлсний дараа нусыг зөөллөж авна / Цагаан хоолыг 7 хоног идэх, 7 хоногоос хойш үхрийн махтай чанаж, жигнэж болгосон хоолыг идэх, хоногт 2-3 л ус, бор цай уухыг зөвлөв. Цагаан хэрэглэлийг бохирдсон тохиолдол бүрт солихыг туслах сувилагчид зааварлав. Эхэд нярайг хангалттай хангалттай, зөв хөхүүлэхийг зөвлөв.</p>
--	---	--

<p>#62 Түлэгдэлт</p>	<p>Зорилго: Түлэгдэлтийн дараах хүндрэлээс сэргийлэх, халдварын эрсдлээс сэргийлэх</p> <p>Ажиглах төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Биеийн ерөнхий байдлын үнэлгээ, - Амин үзүүлэлтийн үнэлгээ - Түлэгдэлтийн байрлал, зэрэг, хувийг ажиглах - Өвдөлтийг үнэлэх, хянах <p>Хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Жинг үзэх - Уян зүү тавих - Эмчийн заалтаар өвдөлт намдаах эмчилгээ хийх - Шархыг халдваргүйжүүлэгч уусмалаар цэвэрлэж - Тосон боолт хийх - Шингэний баланс - Дулаан байлгах - Халдвар хамгааллын дэглэмийг баримтлах - Түлэгдэлттэй хэсгийг хөндийрүүлж, өндөрлөх - Онцгой хяналт <p>Эрүүл мэндийн боловсрол олгох төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Амаар хангалттай шингэн уулгах - Хувцаслалтын зөвлөгөө өгөх - Хоололтын талаар зөвлөгөө - Өөрт болон ар гэрийнхэнд зөвлөгөө өгөх 	<p>Биеийн ерөнхий байдлыг үнэлэхэд байв. Амин үзүүлэлтийг хянаж тэмдэглэв. Өвдөлт хянах хуудас хөтлөв. Жинг үзэхэд байв. уян зүүг гар /хөлд ариун нөхцөлд тавив. Тандалтын хуудсыг хөтлөв. Шархыг 0,5%-н химодин, 0,7%-н тамедины уусмалаар тосон боолт хийв. Шархны тандалтыг бичиж тэмдэглэв. Хоногийн шингэний балансыг хөтлөв. Үйлчлүүлэгчийг аль болох дулаан байлгахыг зөвлөв. #29 халдвар хамгааллын оношийн дагуу Мөчдийн түлэгдэлттэй үед өндөрлөнө. Цээж болон хэвлийн түлэгдэлтийн үед хөндийрүүлж байрлуулна. Амаар хангалттай шингэн уухыг зөвлөв. Биед чөлөөтэй даавуун материалтай үйлчлүүлэгчид эвтэйхэн байх хувцас өмсөхийг зөвлөв. Амин дэм, эрдэс бодисоор баялаг хоолыг өдөрт ойр ойрхон бага багаар хооллохыг зөвлөв. Шархтай харилцахын өмнө болон дараа гарын ариун цэвэр сахих талаар зөвлөгөө өгөв. Онцгой хяналт</p>
--------------------------	--	--

<p>#63 Хөлдөлт</p>	<p>Зорилго:</p> <ul style="list-style-type: none"> - Хөлдөлтийн хүндрэлээс сэргийлэх <p>Ажиглах төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Биеийн ерөнхий байдлын үнэлгээ, - Амин үзүүлэлтийн үнэлгээ - Хөлдөлтийн байрлал, зэрэг, хувийг ажиглах - Өвдөлтийг үнэлэх, хянах <p>Хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Жинг үзэх - Уян зүү тавих - Эмчийн заалтаар өвдөлт намдаах эмчилгээ хийх - Шархыг халдваргүйжүүлэгч уусмалаар цэвэрлэж - Тосон боолт хийх - Шингэний баланс тооцох - Дулаан байлгах - Халдвар хамгааллын дэглэмийг баримтлах - Эмчийн заалтаар хөлдөлттэй хэсгийг марганцтай усанд дүрэх - Онцгой хяналт <p>Эрүүл мэндийн боловсрол олгох төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Амаар хангалттай шингэн уулгах - Хувцаслалтын зөвлөгөө өгөх - Хоололтын талаар зөвлөгөө <p>Өөрт болон ар гэрийнхэнд зөвлөгөө өгөх</p>	<ul style="list-style-type: none"> - Биеийн ерөнхий байдлыг үнэлэхэд байв. - Амин үзүүлэлтийг хянаж тэмдэглэв. - Өвдөлт хянах хуудас хөтлөв. - Жинг үзэхэд байв. - уян зүүг гар /хөлд ариун нөхцөлд тавив. Тандалтын хуудсыг хөтлөв. - Шархыг 0,5%-н химодин, 0,7%-н тамедины уусмалаар тосон боолт хийв. Шархны тандалтыг бичиж тэмдэглэв. - Хоногийн шингэний балансыг хөтлөв. - Үйлчлүүлэгчийг аль болох дулаан байлгахыг зөвлөв. - #29 халдвар хамгааллын оношийн дагуу - Эмчийн заалтаар хөлдөлттэй хэсгийг марганцтай усанд..... дүрэв. - Мөчдийн хөлдөлттэй үед өндөрлөнө. Цээж болон хэвлийн хөлдөлттэй үед хөндийрүүлж байрлуулна. - Амаар хангалттай шингэн уухыг зөвлөв. - Биед чөлөөтэй даавуун материалтай үйлчлүүлэгчид
------------------------	---	---

		<p>эвтэйхэн байх хувцас өмсөхийг зөвлөв.</p> <ul style="list-style-type: none"> - Амин дэм, эрдэс бодисоор баялаг хоолыг өдөрт ойр ойрхон бага багаар хооллохыг зөвлөв. - Шархтай харилцахын өмнө болон дараа гарын ариун цэвэр сахих талаар зөвлөгөө өгөв. - Онцгой хяналт
<p># 64</p> <p>Харах чадвар алдагдах</p>	<p>Зорилго: Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах</p> <p>Ажиглалтын төлөвлөгөө: - Үйлчлүүлэгчийн орчныг харж ажиглах, өөрөө юу хийж чадах талаар асууж орчныг үнэлэх</p> <p>Хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө: - Үйлчлүүлэгчийн ерөнхий байдалыг хянах - Сувилагч үйлчлүүлэгчийн хувьд хамгийн ойрын туслагч байх</p> <p>Үйлчлүүлэгчийн ээлтэй орчин эелдэг соелтой харилцааг бий болгох. -Үйлчлүүлэгчид үнэн зөв мэдээлэл өгөх</p>	<p>-Өөртөө үйлчлэх чадварт сургасан байна</p> <p>-Асран хамгаалагчид өдөр тутмын асаргаа сувилгааны / өөрт хэрэглэгдэх зүйлийг нь бэлтгэж өгөх, тэргэнцэр ,таягорчин хүрээлэн буй/ байдлыг тайлбарлаж ойлголцож сурна</p> <p>-Сувилагч үйлчлүүлэгчийн хувьд хамгийн ойрын үнэнч туслагч сэтгэлийг ойлгон дэмчигч, урам дэм өгөгч, дотны зөвлөгч байна.</p> <p>-Үйлчлүүлэгчийн үг яриаг хүлээцтэй сонсоод харилцан</p>

	<p>-Үйлчлүүлэгчийн ар гэрийнхэнтэй холбоотой байх</p> <p>-Жижиг бүлгийн сургалт зохион байгуулах</p> <p>-Өрхийн эмнэлэг болон хорооны НЭМ-н ажилтантай холбож өгөх</p> <p>Эрүүл мэндийн боловсрол олгох төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Сэтгэл зүйг тайван байлгах - Ар гэрийнхэнд асаргаа сувилгааны зөвлөгөөг өгөх - Хяналтын тасралтгүй хийнэ 	<p>ярилцаж эдгэнэ гэсэн итгэлийг төрүүлж урам зориг өгнө.</p> <p>-Үйлчлүүлэгчид ээлтэй, нээлттэй орчин, эелдэг харилцааг бий болгох</p> <p>-Эмчилгээ сувилгаанд гарсан эерэг үзүүлэлтүүдийг байнга танилцуулах</p> <p>-Үйлчлүүлэгчтэй харилцахдаа алдаа гаргахаас сэргийлэх</p> <p>-Үйлчлүүлэгчийн ар гэрийнхэнд нь сэтгэл санааг дэмжих ганцаардуулахгүй байлгах талаар зөвлөгөө өгөх</p> <p>-Орчин хоол, хувцаслалтын талаар сахиур болон ар гэрт зөвлөгөө өгөх шаардлагатай</p>
--	---	--

